



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-37</i>

1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хургуулна/

5-37

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Төсвийн байнгын хорооны 08 дугаар сарын 21-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 35 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар, Г.Дамдинням;

Чөлөөтэй: Г.Тэмүүлэн;

Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Болормаа, П.Мөнхтулга, З.Мэндсайхан,
Б.Чойжилсүрэн.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, мөн яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Дэлгэрмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, мөн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, мөн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын

дарга Ц.Ариунсанаа, Нийслэлийн Засаг даргын орлогч Н.Мандуул, Ерөнхий сайдын дэргэдэх Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Ч.Золбаяр, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Б.Заяабал, Б.Түвшин, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Нийслэлийн Засаг даргын орлогч Н.Мандуул, Ерөнхий сайдын дэргэдэх Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Ч.Золбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Д.Батлут, Дав.Цогтбаатар, Ж.Батжаргал, Т.Аубакир, Б.Түвшин, Б.Мөнхсоёл, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дараах зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах:

Төслийн 1.3.3-т “Улаанбаатар-Шар Хөтөл-Эрдэнэт авто зам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	6
Бүгд:	17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут саналаа тайлбарлав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 43 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 18 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 21-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим 12 цаг 35 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Ирц 13 болчихсон юм байна. Бүртгүүлсэн гишүүд орж ирье. Ганцхан асуудал юм байна. Бүртгүүлсэн гишүүн 25-аас 56 хувийн ирцтэй байгаа учраас хуралдааныг эхлүүлэхэд бэлэн байна. Гишүүд ороод ирье. 5 минут хүлээгээд тэгээд хэдүүлээ хурлаа эхэлье.

Хуралдаанаа эхэлье. Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье ээ. Байнгын хорооны хуралдааны ирц 56 хувь байгаа учраас хуралдааныг 2024 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Гишүүдийн ирцийг нь би танилцуулчихъя. Миний бие хүрэлцэн ирсэн байна, Аубакир гишүүн ирсэн байна, хуралдаандаа орж ирээрэй, Далайн Батбаяр гишүүн бүртгүүлсэн байна. Рэнцэндоржийн Батболд гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Батжаргал гишүүн орж ирье. Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Жадамбаагийн Баясгалан гишүүн ирсэн байна, бүртгүүлсэн байна, Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна, Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна, Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна, Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн ирсэн байна, Банзрагчийн Түвшин гишүүн ирсэн байна, Даваагийн Цогтбаатар гишүүн ирсэн байна.

Ингээд ирц 56 хувьтай байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг би та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Энэ асуудлыг хэлэлцэхээр байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийн нэр байна уу? Ажлын хэсэг оруулъя. Идэшийн Батхүү байна уу? Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД алга байна. Лханаажавын Мөнхтүшиг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга орж ирнэ, байхгүй байна шүү. Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батсуурийн Баттөмөр Тэргүүн шадар бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, Пэрэнлэй Мөнхбат Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх, Чулуунцэцэгийн Золбаяр Ерөнхий сайдын дэргэдэх Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Нямдэлэгийн Мандуул НЗД-ын орлогч, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга. Энэ дуудсан улсууд ер нь дийлэнх нь байхгүй байна. Орж ирнэ шүү. Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын зохицуулалтын газрын дарга,

Эрдэнэбилигийн Батболд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Судалгаа хөрөнгө оруулалтын газрын дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Содовжамцын Цагаанхүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны БХЗГ-ын дарга, Пүрэв-Очирын Дэлгэрмаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Болдын Отгонцэцэг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Отгонтогтохын Энхмөнх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга, Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны хэлтсийн дарга, Цэен-Ойдовын Ариунсанаа Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Тогоогийн Гантогтох ХХААХҮЯ-ны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын бодлогын газрын дарга, Мөнхөөгийн Батбаяр Хөшигтийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа төсвийн дарга. Ийм улсууд нэр ирүүлсэн байна юу? Энэ улсууд орж ирье. Одоо ингээд гишүүд асуулт асууна.

Дийлэнх нь байхгүй байгаад байна. Энэ улсуудыг дуудъя. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуулт асуух гишүүдийнхээ нэрсийг авч байя. Асуулт асуух гишүүд байна уу? Батлут гишүүн, Заябал, Түвшин гуравхан гишүүн юм уу, айн? Энэ чинь одоо 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр шүү дээ. Ингээд 3 гишүүнээр асуултыг тасаллаа. Асуултад хариулах улсуудаа

Засгийн газрын холбогдох яамдын Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар орж ирье.

Батлут гишүүний асуултад хариулчихаар улсууд байх шиг байна уу? Тэр нь дээр байх аа. Тэгэхгүй бол дахиад асуух юм гараад. Яамдын холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон улсуудыг дуудъя аа.

Батлут гишүүн асуултаа асууя. Батлут гишүүн асуултад хариулах холбогдох яамны хүн байхгүй бол дуудна шүү манайхан. Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэлэлцээж байна. Тэгээд өнөөдөр бол энэ их чухал зүйл. Энэ шинэ Засгийн газрын гарааны том ажлын эхлэлийг тавих гэж байна. Нэг л асуудал байгаа. Хүний хөгжил гэдэг зүйлийг бид нар 1 дүгээрт тавих ёстой. Өнөөдөр хүнээ хөгжүүлсэн улс орон л хөгжлийн өндөр түвшинд хүрдэг. Тэгвэл өнөөдөр хүний хөгжил ярих юм бол хот хөдөөд байгаа иргэдийн ажиллаж амьдрах нөхцөл байдал, төрийн үйлчилгээ, нийгмийн үйлчилгээ авах боломжууд ямар байгаа гэдгээ харах ёстой гэж харж байна. Хөдөөд, сумдад хөгжлийн ямар концепт гаргаж байгаа юм бэ? Хөгжлийн хөтөлбөрүүд. Хот хөдөөгийн ялгаа өндөр болсон учраас тэнд ажиллаж байгаа эмч, багш, төрийн албан хаагчид хүний нөөцийн хомсдолд орсон байна. Тэнд бизнес эрхлэх боломж хомс байна. Сайхан амьдрах боломжууд хомс байна. Сумдад шүү. Тэнд байгаа нь гэвэл эрүүл сайхан агаар л байна. Эсрэгээрээ хотод юу болж байгаа вэ гэвэл төвлөрөл байна түгжрэл байна. Энийг яаж сайжруулах яаж өөрчлөх вэ гэвэл сумдад нийгмийн үйлчилгээ сайн авдаг, бизнес эрхлэх таатай боломжийг олгодог тэнд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангадаг тийм орчин

нөхцөлийг бүрдүүлж байж хөдөөг зорьсон урсгал бий болж суманд, хот, хөдөөгийн ялгарал арилна, бас тэнцвэртэй болж өгнө гэж харж байгаа. Тэгэхээр энэ ирэх 4 жилд яг үүн рүү чиглэсэн ямар бодлогын хэрэгжилтүүдийг төлөвлөсөн юм бэ? Бизнес эрхлэх, амьдрах орчныг сайжруулах, цалин хөлсийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах сумдад шүү. Энэ дээр нэг хариулт аваадахъя аа.

Хоёрдугаарт нь энэ ерөнхийдөө хойд бүс нутагт аж үйлдвэржлийн бүс нутаг болно гэж зорьж байгаа. Энэ бүс нутгийн аж үйлдвэржүүлэх процессыг нэн тэргүүнд шийдэхэд хамгийн чухал зүйл эрчим хүчний хангамжийн асуудал. Тэгээд өнөөдөр Бөөрөлжүүтийн ДЦС-ын асуудал яригдаж байна л даа. Тэгэхдээ 2022 оноос л хойш яригдсан. 300 мегабайт гээд. Энэний төсөвт өртөг нь одоо хэдэн төгрөг байна. Одоо ажил нь ямар явцтай явж байгаа юм бол? Ер нь бид бүхэн том том төслүүдээ хэрэгжүүлнэ гээд 14 мега төслийг ингээд л гаргаж ирээд л явж байна. Энэ төслүүд дээр манай аудитын байгууллага ер нь нийцлийн аудит хийсэн үү? Өнгөрсөн удаад 2023 онд шиг санаж байна. Тухайн жилийн 400 орчим.

Ц.Даваасүрэн: Яах юм асуултаа авах юм уу? Батлут гишүүнд нэг минут нэмж өгье. Асуултаа гүйцээ.

Д.Батлут: 400 орчим арга хэмжээний 200 орчимд нь нийцлийн аудит хийхэд 70-аас 80 тэрбум төгрөгийн нэмэлт зардал тооцсон нь батлагдаж гарсан шүү дээ. Одоо энэ том төслүүд дээр бид нар нийцлийн аудит хийж чадаж байгаа юу, үгүй юу. Миний л сонссоноор энэ Бөөрөлжүүтийн төсөвт өртөг нэлээн өндөр хувиар нэмэгдсэн гэдэг мэдээлэл байгаа. Хэрвээ нэмэгдсэн бол ямар учир шалтгаанаар нэмэгдсэн бэ гэдэг дээр нь хариулт өгөөч.

Бид нар эрчим хүчнийхээ салбарыг эрүүлжүүлж чадаж байж л цаашиад нөгөө анхан шатны иргэндээ, айл өрхдөө хямдарсан эрчим хүчээр хангана. Одоо

эрчим хүчний үнэ чөлөөлөх асуудал яригдаж байгаа. Асар олон зүйлүүд байгаа. Тухайлах юм бол сэргээгдэх эрчим хүч гээд л олон жилийн өмнө гэрээ байгуулчихсан. Тэр нь улсад ашиггүй хувийн компаниуд жилийн 60, 70 тэрбум төгрөгийн ашиг олгоод явж байгаа тийм төслүүд байна. Тэрийгээ ч зогсоож чадахгүй явж байгаа шүү дээ өнөөдөр. Энэ дээр надад нэг хариулт өгөөч ээ.

Гуравдугаарт нь Хөвсгөл аймгийн тэр дулааны станцын асуудал.

Ц.Даваасүрэн: Хариулсны дараа дэгээрээ. Дулааны юу болчихсон, дулааных болчихож байгаа. Тэр нь болчихож байгаа юм. Тэр чинь нөгөө төсөв дээр яригдана болчихож байгаа юм. Тэр Хөвсгөлийн дулааны станцын юугаар би өөрийнхөө хуучин хэрэгжиж байсан төсвөөс татгалзаад дулааны станцын төсөвт өрх рүү нь шилжүүлээд явчхаж байгаа. Тийм учраас Хөвсгөлийн дулааны станцын асуудал шийдэгдчихэж байгаа юм. 16 дээр 3 тэрбумаар нэмэгдээд ингээд 19 тэрбум болоод тэр асуудалгүй болж байгаа юм.

Батлут гишүүний асуултад Эрчим хүчний яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Нийслэлийнх. Нийслэлийнхэн чинь тэр Бөөрөлжүүтээс нөгөө 300 тэрбумаар хувийг нь худалдаж аваад байгаа гэлүү? 300 гэсэн байх аа? Байгаа нь хаанах байна? Эдийн засаг, хөгжлийн яамнаас байна уу? Хүний хөгжлийн талаар ялангуяа орон нутгийн боловсон хүчин тогтвортой ажиллуулах чиглэлээр тэнд шилдэг боловсон хүчнүүдийг аваачих асуудлаар төрөөс цаашид ямар бодлого баримтлах юм бэ гэж. Эдийн засгийн хөгжлийн яам хариулъя байна уу? Эдийн засгийн сайд, эдийн засгийн Төрийн нарийн бичгийн дарга хоёулаа ингэмээргүй юм. Эдийн засгийн сайдыг дууддаг юм уу? Нийслэл хариулж байя. Тэр нөгөө нэг Бөөрөлжүүтийн юунаас бонд авсан талаараа, хувьцааг нь авчхад байгаа юм уу?

Н.Мандуул: Гишүүний асуултад хариулъя. НЗД-ын I дүгээр орлогч Мандуул байна.

Бөөрөлжүүт. Ер нь бол одоо яг энэ Улаанбаатар хотын хэмжээнд бол эрчим хүчний асуудал бол тулгамдсан асуудал болж байгааг бүгд мэдэж байгаа. Тэгээд нийслэлийн зүгээс бол энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд бас өөрсдөө ажил хийгээд ямар ч байсан гэсэн энэ өвлийн хүндрэлтэй асуудлыг давъя гэдэг дээр бас шийдэл гаргаад явж байгаа. Үүн дээр бол 2 ажил өвлөөс өмнө хэрэгжиж эхэлнэ гэсэн тийм хүлээлттэй байна.

Нэгдүгээрт нь бол Бөөрөлжүүтийн цахилгаан станц. Энэ маань бол цэвэр хувийн хөрөнгө оруулалтаараа хийгдэж байгаа бараг 10 гаруй жил үргэлжилж байгаа ийм төсөл байгаа юм аа. Ер нь бол төслийн хүрээнд цаашидаа 300мвт-ын хүчин чадалтай станц болгохоор төлөвлөж байгаа юм байна лээ. Гэхдээ эхний блок 150 мвт-аа энэ онд өвлөөс өмнө ашиглалтад оруулна гэсэн тийм төлөвлөгөөтэй ажил хуваарийн дагуу явж байгаа. Засаг дарга бид хэд бас газар дээр нь очиж бас танилцсан. Ер нь бол ажил нь хурдан явж байгаа. Нүүрсний хувьд дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор олон улсын хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө босгох бараг боломжгүй болчихсон байгаа. Тэгэхээр нийслэлийн хувьд бол сая 6 сард 300 тэрбумын бонд гаргаад түүнийгээ дамжуулан зээлдүүлсэн байгаа юм.

Тэгэхээр бидний хувьд бол тэр хувийн хэвшлийн станцад ямар нэгэн хувьцаа эзэмшиж байгаа тийм зүйл бол байхгүй ээ. Эрчим хүчний тал дээр бас 2 дахь нэг хийгдэж байгаа ажил бол батарей хураагуурын станц байгаа. Тендерийн ажил нь дууссан. Одоо ингээд ажил нь эхлэх гээд явж байгаа. Өвлөөс өмнө бас ашиглалтад орно. Энэ маань бол 50мвт тэгээд 200мвт цаг гэсэн ийм үзүүлэлттэй батарей хураагуурын станц байх юм. Өнгөрсөн жил ашиглалтад

орсон тэр сонгино дээр байдаг юуны Азийн хөгжлийн банкаар хэрэгжсэн тэр хураагуурын станцтай ер нь үзүүлэлтийн хувьд төстэй тийм зүйл. Шөнөдөө илүүдэл гарсан эрчим хүчийг хурааж батарейгаа цэнэглээд өдөр яг оргил цагийн 5-аас 9 цагт төвийн эрчим хүч рүү цахилгаан нийлүүлэх ийм байдалтайгаар үүнийг тэгээд бид хэд харж байгаад цаашидаа хэрвээ боломжтой байх юм бол тэр хавьд нь ногоон эрчим хүчний эх үүсвэрүүд нэмээд тэгээд цаашидаа өргөжүүлээд явж болох юм гэсэн тийм байдалтайгаар ажлыг нь явуулж байна аа.

Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Хувийн компанид орон нутгийн төсвөөс зээл олгох хуулийн хэмнэлт байдаг юм уу? Чи тэрийг нь хувийн компанид. Хувьцааг нь аваагүй юм байна тэ? Миний ойлгосноор дамжуулан зээлдэх юм байна. Тэгэхдээ тэр Батлут гишүүний асуугаад байгаа өртгийг нь бас та нар тооцсон уу? Тэрэнд нь ямар нэг тооцоо судалгаа хийсэн эрчим хүчнийх дээр нэмээд юу Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, орон нутгаас хувийн компани гэдэг юм уу хувийн төсөлд зээл олгох тийм эрх хуулиараа төсвийн хуулиараа байдаг юм уу? Нийслэл хуулиараа тийм юм байдаг юм уу?

Н.Мандуул: Яг бүтцийн хувьд бол нийслэлийн харьяанд байдаг тэр хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани байдаг юм. Тэр сангийн менежментийн компани дээр хөрөнгө оруулалтын сан үүсгээд түүгээрээ дамжуулаад зээлийн гэрээ нь хийгдээд явсан байгаа. Тэгэхээр хуулийн хувьд энэ боломжтой асуудалгүй.

Ц.Даваасүрэн: Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга байна уу? Төсвөөс дамжуулан зээлдэхийг төсвийн хуулиараа хорьчихсон биз дээ? 2 номерын микрофоныг өгье. Энэ микрофоноо ажилд оруулъя манайхан.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Төсвийн тухай хууль дээр зээл олгохтой холбоотой зүйл бол 24¹ дээр байгаа. Энэ дээр зөвхөн улсын төсвөөс олгох асуудлыг зохицуулчихсан байгаад байдаг. 24¹ дээр 3 төрлөөр зээл олгож болнооо гэххэж байгаа юм.

Нэгдүгээрт бол доод шатынхаа төсвийн дутагдлыг нөхөх зорилгоор улирлын чанартай буюу тухайн жилдээ олгоод буцааж авч болохоор өөрөөр хэлбэл аймагт зээл олгох боломж байгаа. Хотод бол бас зээл олгох боломж байгаа.

Хоёрт нь бол Засгийн газрын тусгай сангийн хуулиар зориулсан байдлаар зээл олгож болно. Энэ нөгөө Тариалан эрхлэлтийг дэмжих сан ч юм уу, ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сан ч байдаг юм уу эндээс олгож байгаа зээлийг мэдээж хэлж байгаа.

Гурав дахь нь бол Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу дамжуулан зээлдүүлэх гээд ийм 3 нөхцөл одоогийн хууль дээр мөрдөгдөж байгаа. Тэгэхдээ энэ зөвхөн нөгөө улсын төсвөөс олгох зээл байдаг.

Ц.Даваасүрэн: Ялгаа байхгүй л дээ төсвийн зээл л юм чинь. Төсвийн зээлийг зохицуулж байгаа нь ер нь наад зохицуулалт чинь л байгаа шүү дээ тэ?

М.Санжаадорж: Тийм тэрнээс биш орон нутаг гэж байхгүй.

Ц.Даваасүрэн: Эдийн засгийн хөгжлийн яамнаас хэлтсийн дарга байна гэсэн үү? Эдийн засгийн хөгжлийн яамнаас хуулиараа байна шүү дээ энэ Их Хурал дээр асуудал хэлэлцэж байхад наад зах нь ер нь сайд улс төрийн албан тушаалтан хариулж байх хуультай. Гэтэл сүүлийн үед бүүр ахлах мэргэжилтэн хариулдаг болсон байна шүү. Ямар ч гэсэн тэгээд тэр 6 номерын микрофон. Хэлтсийн дарга Батлут

гишүүний асуугаад байгаа хөдөөд боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах шилдэг боловсон хүчнийг суурьшуулж ажиллах чиглэлээр төрөөс хүний нөөцийн бодлогын хүрээнд ямар бодлого төлөвлөж оруулж ирсэн юм бэ? Энэ хөтөлбөрт гэж асуугаад байна хариулъя. 6 номерын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Би Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан.

Яг манай нөгөө Бүсчилсэн хөгжлийн газрын дарга орж ирж байгаа. Яг энэ хажуу талд Аюулгүй байдлын байнгын хороон дээр асуултад хариулаад байж байна. Тэндээс орж ирэхээр нь дэлгэрэнгүй хариулт өгүүлье.

Ц.Даваасүрэн: Танайх чинь Төрийн нарийн бичгийн даргатай биз дээ?

Л.Энх-Амгалан: Ялгаагүй Аюулгүй байдлын байнгын хороон дээр яг тэнд хуралд сууж байгаа.

Ц.Даваасүрэн: Хоёулаа байх тийм шаардлага байгаа юм уу? Нэгийг нь дуудчихъя. Яаралтай хариулуулъя. Аль нэгийг нь дуудчих.

Микрофон ажиллахгүй бол протокол хөтлөгдөхгүй байна гэсэн үг шүү дээ. Энэ протокол хийгдэх ёстой шүү. Тэгэхээр протокол хийгдэхгүй байна гэсэн үг шүү дээ. Микрофон нээгдэхгүй байгаа юм чинь. Ороод ирэхээр нь нэмээд хариулуулчихъя тэгэх үү? Батлут гишүүн ээ тодруулга байгаа юм уу? Батлут гишүүн Бөөрөлжүүтээ тодруулж байя. Эрчим хүчний хүнийг дуудъя. Эрчим хүчний хүнээс тэр өртгийг нь асуугаад байх шиг байсан?

Энэ чинь бүх л яам ирж Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хүн ирсэн байна уу? Эрчим хүчнээс байна уу? Тавинбэх яасан? Газрын даргыг нь дуудаач дээ. Танайх тэр хоёул хоёулаа орж байх ямар хэрэгтэй юм бэ? Нэг нь наашаа ир л дээ. Нэг нь ирээд

асуултад хариул. Тийм 5 номерын микрофон руу Эрдэнэбаяр дарга наашаа суучих. Тэр нөгөө мөрийн хөтөлбөрт хөдөө орон нутагт боловсон хүчний бодлого хүний нөөцийн асуудлуудыг хэрхэн төлөвлөж оруулж ирсэн бэ? Тэнд тогтвор суурьшилтай ажиллах нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх шилдэг боловсон хүчнүүдийг шилжүүлэн суурьшуулах чиглэлээр төрөөс ямар бодлого баримтлах юм бэ? Ирэх 4 жилд гэж асуусан байгаа. Тэрэнд хариулъя.

Д.Эрдэнэбаяр: Бүс орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр. Эдийн засгийн хөгжлийн яамнаас асуултад хариулъя.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөө орон нутагт ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлнэ гээд. Бүсчилсэн хөгжлийн бодлогын сүүлийн заалтад бүлэг заалтыг оруулж өгсөн. 2023 онд Монгол Улсын Засгийн газраас орон нутаг руу шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэхтэй холбоотой бүх аймгийн Засаг дарга нар болон яамдын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг гарч ажилласан. Энэ хүрээнд бол орон нутгийн иргэдээс өгч буй саналуудыг нэгтгэн бүлэг 12 заалтыг гаргасан. Үүний нэг нь бол ипотекийн асуудал, орон сууц барих хувийн компаниудын татварын асуудал, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гарч буй зарим зардлыг хариуцах зэрэг одоо иргэдээс ААН-ээс гарсан саналыг багцалж тусгасан. Энэ үйл ажиллагааг ирэх 4 жил үргэлжлүүлэх бодлогыг багцаар нь тусгасан. Мөн бүс орон нутагт үйлдвэр үйлчилгээ бизнес хийх таатай орчныг бүрдүүлэх бүлэг заалтыг бүс болгон дээр оруулж өгсөн.

Өөрөөр хэлбэл орон нутагт үйлдвэр, үйлчилгээ, тээвэр ложистик, бизнес эрхлэх төвүүдийг байгуулах хувийн хэвшлийг тэргүүн ээлжид дэмжих дэд бүтэц болон холболтын эдийн засгаар дэмжих өөрөөр хэлбэл зах зээлийг нь нээж өгөх борлуулалтаар нь дэмжих ийм бодлогыг бүс болгонд тусгаж өгсөн.

Тухайн бүсийн байгалийн нөхцөл нөөц онцлог байдлаас хамааруулж ТЭЗҮ-ийг хувийн хэвшилтэй хамтран хийх үүний хүрээнд чөлөөт бүс, тусгай бүс, үйлдвэр технологийн паркуудыг бүсчилж байгуулах ийм саналыг багцалж оруулж өгснөөрөө бас нэлээн.

Ц.Даваасүрэн: Эрчим хүчний яам хариулъя. Тэгээд дараа нь хэн гишүүн тодруулах гээд байх шиг байна? Батлут гишүүн. Эрчим хүчний яам, Хөдөө аж ахуйн яамны улсуудыг оруулъя. Манай ажлын хэсгийнхэн хэлсэн үү, юу гэсэн тэгээд. Үгүй тэгэхдээ бүгдээрээ тийшээ орж яах юм бэ. Нэг нь наашаа ирээд хариул гэж хэл л дээ. Яах вэ Байнгын хороо давхцаад зоонон төвөгтэй байх шиг байна. Тэгэхдээ нэгэнт цагийнхаа хуваарийн дагуу хуралдаж байгаа учраас яваад аль нэг газрын газрын даргын ч юм уу, Төрийн нарийн бичгийн даргын нэг нь асуултад хариул гэж хэл. Тэгээд асуултад хариулчхаад буцаад очиж болно шүү дээ. Нэг газраа суугаад байх биш. Тавинбэх дарга ороод ирлээ.

Тэр Бөөрөлжүүтийн төслийн төсөвт өртөг өндөр байна. Энэ талаар ямар мэдээлэл байна вэ гэж асуугаад байна. Батлут гишүүн тэрийг нь хариулъя.

Н.Тавинбэх: Эрчим хүчний яам Тавинбэх. Батлут гишүүний асуултад хариулъя. Аюулгүй байдлын байнгын хороон дээр хуралд оролцож байсан учраас асуулатыг бүрэн сонсож чадсангүй ээ. Тэгээд Бөөрөлжүүтийн станцын талаар асуусан байна гэж ойлголоо.

Ц.Даваасүрэн: Тийм Бөөрөлжүүтийн нөгөө төсөвт өртөг нь хэт өндөр байгаа юм биш үү л гэж асуугаад байна лээ.

Н.Тавинбэх: Бөөрөлжүүтийн Дулааны цахилгаан станц 600 мвт-ын хүчин чадалтай 2 хэсэгчилж ашиглалтад оруулна. 1 дүгээр шатын 150 мвт-ын блок энэ оны 10 дугаар сард энэ оны өвлийн их

ачааллаас өмнө ашиглалтад оруулахаар тохиролцоод ажиллаж байна.

Нэгдүгээр шатын 2 дахь үе ирэх оны 6 сард багтаж ашиглалтад орох ёстой. Энэ 1 дүгээр шатны ашиглалтад орох нөхцөл байдлаас шалтгаалаад 2 дугаар үе шатын ашиглалтад орох хугацааг тодорхой болгоно гээд одоогоор эцэслэж чадаагүй байгаа. Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станц хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа. Бид хөрөнгө оруулагчдаа зөвхөн цахилгаан эрчим хүчийг худалдаж авах гэрээг л байгуулсан. Хөрөнгө оруулалтын асуудалд бид оролцохгүй байгаа. Бидэнд ирсэн мэдээллээр нийслэлээс барилга угсралтын ажилд санхүүжилт очсонтой холбоотой тодорхой хэмжээний зээл авсан гэдэг ийм мэдээлэл байгаа. Бөөрөлжүүтийн дулааны станцын эрчим хүчний системд нийлүүлэх эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэхийн тулд бид нар харин сүүлд Бөөрөлжүүтээс Сэргэлэн улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа 220 киловольтын дэд станц руу 84 км 220 киловольтын шугам барьж ашиглалтад оруулахдаа.

Ц.Даваасүрэн: Тавинбэх гишүүний 3 дугаар микрофоныг өгье. Нэг минут нэмье.

Н.Тавинбэх: Холбоотойгоор худалдаж авах эрчим хүчний үнийг нэмэгдүүлэх хэлцлийг хийж байгаа. Одоо эцэслээгүй байна. Бөөрөлжүүттэй хийсэн Цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээгээр бол 1 квт-ын цахилгаан эрчим хүчийг гарааны үнэ болгож 7 центээр энэ нь нэг жилийн хугацаатай үргэлжилнэ. Энэ нэг жилийн хугацаанаас цаашаа 8.4 центээр худалдаж авахаар 8 центээр худалдаж авахаар ингээд гэрээ хийсэн байгаа. Энэ ямар нэгэн тохируулга байхгүй. 28 жилийн хугацаанд энэ гэрээ хатуу мөрдөгдөхөөр тохирчихсон байгаа.

Ц.Даваасүрэн: Тодруулах юм уу? Батлут гишүүн тодруулъя. Та нөгөө

тарифыг нь асуугаад байгаа юм уу, өртгийг нь асуугаад байгаа юм уу?

Д.Батлут: Энэ Бөөрөлжүүттэй холбоотой магадгүй энэ хувийн хэвшилд улсаараа өрөнд орчих вий дээ. Улсаараа хамааралтай болоод. 8 центээр авах юм байна 1квт-ын тийм үү. Тэр чинь 270, 280 төгрөг. 300-аад төгрөг болох нь байна шүү дээ. 1квт цахилгаан эрчим хүчний төлбөр. Тэгээд эрчим хүчний үнэ төлбөрөө бид нар чөлөөлнө гээд байгаа. Тэгээд хэд болох юм бол цаашилаад. нэг монопол аж ахуйн нэгж болоод л дээрээс нь бид нар улсаар өрөнд орсон нэг юм болох вий дээ? Эсвэл наад концессын гэрээний чинь учрыг би олохгүй. Мэдээллийг нь олж авч ерөөсөө чадахгүй байгаа?

Ямар хэлбэрээр концессын гэрээ хийх гэж байгаа юм болоо? Тэгээд бас төрөөс төсвөөс мөнгө оруулчихсан байдаг. Энэ нэг учир явдлыг надад нэг нэлээн сайн тайлбарласан мэдээлэл өгөөч гэж хүсье.

Хоёрдугаарт нь энэ хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр хариулж байгаа Эдийн засгийн хөгжлийн яамныхаан нэг зүгээр жижүүрийн үгээр аргалаад сурчихсан юм. Та нар асуудалд нэг тодорхой хариулт өгчхөөч. Төрийн албан хаагчийн цалинг тэдэн хувь нэмэгдүүлнэ, хөдөө сумдад. Хөдөө сумдад тийм боломжтой нөхцөлийг бий болгоно. Өнөөдөр сумдаа хөгжүүлж байж улсын хөгжлийн асуудал ярина шүү. Улаанбаатарыг биш энэ түгжрэлийг алга болгоё гэж байгаа бол тэр суманд хүн ажиллаж амьдрах нөхцөл боломжийг л бүрдүүлэх ёстой. Тэр боломж нөхцөлийн хөрөнгө оруулалтуудыг хийдэг болох ёстой гэж харж байгаа.

Эдийн засаг, хөгжлийн яам тэгээд яг яаж төлөвлөсөн юм бол? Хариулж байгаагаар нь мэдэхгүй дээ. Энэ 4 жилд яг үүн рүү чиглэсэн хөрөнгө оруулалт хийхгүй нь л гэж харлаа. Мэдээлэл өгөөрэй гэж хүсье.

Ц.Даваасүрэн: Тавинбэх дарга эхлээд хариулъя. 3 номерын микрофон өгье.

Н.Тавинбэх: Батлут гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яам.

Бөөрөлжсүүтийн дулааны цахилгаан станц концессоор бариагүй. Бөөрөлжсүүтийн дулааны цахилгааны станц. Хувийн хэвшил өөрийн хөрөнгөөр эх үүсвэр бариад бүтээгдэхүүнээ төрд зарж байгаа. Бүтээгдэхүүний үнэ дээр л бид нар тохирч байгаа. Тэрнээс цааших асуудалд оролцох шаардлагагүй. Оролцоогүй. Бид худалдаж авах эрчим хүчний хэмжээ, бүтээгдэхүүний нэгжийн үнэ 2 дээр тохироод л явж байгаа. Энэ цаг үед эрчим хүчний дутагдалд орсон учраас бүтээгдэхүүн эрчим хүч цахилгаан эрчим хүч хэрэгтэй байгаа. Энэний дагуу хэрэгтэй эрчим хүчийг л худалдаж авч байгаа гэж ингэж ойлгож болно. Би танд шаардлагатай мэдээллийг яаман дээр байгаа шаардлагатай мэдээллийг бичгээр хүргүүлъя. Энэ төсөлтэй холбоотой.

Ц.Даваасүрэн: Гол нь яах вэ нөгөө нэг танайхтай худалдан авах, худалдах гэрээ хийж байгаа. Худалдан авах, худалдах гэрээн дээр тарифын өртгийг 8 цент нэлээн өндөр байна. Иргэд дээр ирэх ачаалал нэмэгдэх юм байна. Үнэ чөлөөлөхөөр гэж л асуугаад байгаа юм байна л даа. Тэрэнд нь хариулъя. 3 номерын микрофон.

Н.Тавинбэх: Монгол Улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний хэрэглэгчийн үнэ өртгөөсөө доогуур зарж байгаа. Энэ үнэтэй харьцуулбал шинээр орж байгаа эх үүсвэрүүдийн бөөнөөр худалдаж авах бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа. Бид энэ алдааг өөрөөр хэлбэл хэрэглэгчийн үнэ өртгөөс нь доогуур зарж байгаа алдааг өртөгт нь дор хаяж хүргэчихвэл ийм хүндрэл гарахгүй ээ. Үнэхээр өнөөдөр хэрэглэгчийн дундаж үнэ өртгөөс нь доогуур тогтоосон энэ үнэ 6.2 цент байгаа. Америк.доллаароор

илэрхийлбэл. Энэ худалдаж авах үнэ нь гарааны үнэ 7, цаашид худалдаж авах үнэ 8 цент. Тэгээд бид өртөгт нь нийцүүлэхээр ажиллаж байгаа. Энэ 8 орчимд. Урьдчилж хэлэх боломжгүй 8 орчимд манай эрх бүхий байгууллага тооцоолол хийчихсэн явж байгаа. Энэ үед бол хэрэглэгчийн үнэ ороод үйлдвэрлэгчээс бөөнөөр авах үнийн зөрүү бага.

Ц.Даваасүрэн: Тэгээд нөгөө шугам сая тэр нөгөө Бөөрөлжсүүтээсээ Сэргэлэн орох шугам тэд нар хийгээд ирэхээр бас наадах тариф дээр чинь ахиад нэмэгдэх үү? 3 номерын микрофоныг өгье.

Н.Тавинбэх: Системийн бүтээгдэхүүн худалдаж авах чадамжийг нэмэгдүүлэхийн тулд би түрүүн хэллээ. Бөөрөлжсүүтийн эх үүсвэрээс Сэргэлэн рүү шинэ шугам татаж байгаа. Уг нь хуучин гэрээгээр бол Бөөрөлжсүүтээс Багануур, Багануураас Улаанбаатар руу бүтээгдэхүүн нийлүүлэх шугамаа дэд бүтцээр бүтээгдэхүүн нийлүүлэгдэх ёстой байсан. Энэ шинэ хөрөнгө оруулалт хувийн хэвчлээр хийлгэснээр үнэ нэмэгдэхгүй. Энэ эх үүсвэрээс худалдаж авах эрчим хүчний хэмжээ нэмэгдэж байгаа. Энэ эх үүсвэрийн ажиллах цагийг бид нар нэмж өгч байгаа.

Ц.Даваасүрэн: Микрофоноо зохицуулахгүй бол нөгөө миний ярьж байгаа энэ хариулж байгаа асууж байгаа энэ бүгд ерөөсөө сонсогдохгүй байгаа юм байна шүү. 5 номер та нарыг гол нь нөгөө энэ хөдөө орон нутагт ажиллах боловсон хүчний асуудал дээр цалин хөлсний асуудал энэ хоёрхон л асуудал байгаа. Цалин хөлс нийгмийн хангамжийн асуудал. Одоо жишээлбэл нөгөө хөдөөг орон сууцжуулах асуудал. Энэ юмнууд ирэх 4 жилийн мөрийн хөтөлбөрт цалинг хэдэн хувиар нэмэхээр ингэж явж байгаа юм. Нийгмийн хамгааллын чиглэлээр нь барилга орон сууцтай холбогдолтой асуудлуудыг нь яах гэж байгаа юм. Мөн бас нөгөө нэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь тодорхой хөнгөлөлтүүдийг үзүүлъя гээд Ерөнхий сайд чинь бас сая юу Их Хурал

дээр хэлэхдээ хэлчихсэн шүү дээ. Одоо жишээлбэл тэдэн жил ажиллаад ингэвэл мэргэжлээ сургах, мэргэжлээ мэдлэгээ дээшлүүлэхэд нь ингэнэ ингэнэ энэ тэр гээд. Иймэрхүү яг тодорхой хариултыг Батлут гишүүн шаардаад байна шүү.

Хариулъя 5 номерын микрофон өгье.

Д.Эрдэнэбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр Батлут гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4-д орон нутгийн хөгжил гэсэн бүлэг байгаа. 1.4.1.1-ээс 8 хүртэл бол төрийн албан хаагчдыг дэмжихтэй холбоотой заалтууд байна. Тухайлбал орон нутгийн нэмэгдлийг төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож, улсын төсвөөс төрийн захиргааны албан хаагчид 80 хүртэл хувийг нэмэгдүүлэх эрхийг аймгийн иргэдийн хуралд олгох. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан бол алслагдсан дүүрэгт анх орон сууц авахад нь 3 хувийн хүүтэй ипотекийн хөнгөлөлтийн зээл олгох бодлогыг үргэлжлүүлэх. Мөн төвлөрлийг сааруулах хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-үүдийг дэмжих нэг хувийн хүүтэй 500 сая төгрөг хүртэлх зээл олгох бодлогыг үргэлжлүүлэх гэх мэт 8 заалтыг тусгасан байгаа. Мөн орон нутагт байгаа Политехникийн коллеж МСҮТ-ийг өргөтгөн шаталсан хэлбэрээр косен хэлбэрт шилжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан. Өөрөөр хэлбэл орон нутагт ажиллаж амьдарч байгаа иргэд заавал Улаанбаатар хотод орж ирж дээд боловсрол авах биш тэндээ байгаа МСҮТ, Политехникийн коллеждоо үргэлжлүүлэн сурах хэлбэрээр дээд боловсрол аваад аж үйлдвэрийн хувьсгал буюу тэндээ үйлдвэр үйлчилгээний мэргэшсэн ийм ажилтан болох бодлогыг хийхээр тусгасан. Өмнөговь аймаг, Дархан аймаг бол энэ бодлогыг маш

амжилттай хэрэгжүүлээд явж байгаа. Энийг цааш нь 21 аймагт үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан байна. Хамгийн гол орж байгаа нэг заалт бол орон нутагт үйлдвэр үйлчилгээний худалдааны цогцолбор байгуулахтай холбоотой төслийг хэрэгжүүлэхээр тусгасан Азийн хөгжлийн банкны 735 сая доллар Улсын Их Хурлаар батлагдаад бэлэн байж байгаа. Мөн “цагаан алт”, “хүнсний хувьсгал” зэрэг хөтөлбөрөөрөө.

Ц.Даваасүрэн: Дутуу хариулсан гэвэл та бас тодруулж болно шүү дээ? Батлут гишүүн тодруулъя.

Д.Батлут: Тэр Бөөрөлжүүт их чухал ач холбогдолтой станц. Тэгээд яах вэ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт л гээд байна. Төсвөөс мөнгө орчихсон байгаа. Тэгээд зардал нь өсөөд нэг улсаараа л нэг компанийн карманд орчихоод өндөр цахилгааны хэрэглээ төлбөр төлдөг болчихсон явж байх вий дээ хэдэн жилийн дараа. Өнөөдөр ч яах вэ гоё яриад л гоё хариулаад өнгөрчихлөө.

Хоёрдугаарт нь энэ хүний хөгжлийн бодлого тэнд ажиллаж амьдрах асуудал гэдэг чинь аж үйлдвэрийн цогцолбор барих гээд олон асуудал биш ээ. Иргэн айл өрх бүрийн санаачилгыг дэмжсэн тэд нарын ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, жижиг оврын дулааны станц барьсан, орон сууцжуулах хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн. Улаанбаатар хотод төв суурин газар байдаг тэр би орчныг үйлчилгээг л тэр сум хүсээд байна шүү дээ. Суманд байгаа иргэд. Хэрвээ тэгж чадах юм бол тэнд л хүмүүс очиж амьдарна. Энийг хийх талаар тодорхой бодитой хөрөнгө оруулалт юу байна аа. Урьдын 4 жилийн ярьсан тэрнээс өмнө ярьж байсан зүйлүүдээ битгий яриад байгаа ч гэж байгаа юм. Копи, паст хийсэн нөхдүүд л орж ирэх юм даа. Энэ дунд шатны энэ нөхдүүд энэ асуудалдаа жосоохон онцгой анхаарч яг тэр хөдөө орон нутагт, ямар асуудлууд тулгамдаад байгаа юм бэ? Явал бидний энэ асуудлыг

шийдэх боломж байна вэ гэдэг дээрээ судалгаа хийхгүй утсаар мэдээлэл аваад л сайхан копи, наст хийдэг асуудлаа л больчихмоор байгаа юм даа.

Ингэх л юм бол та нар хөгжлийн нэг зөв зураглалыг гаргаж ирнэ. Чадахгүй бол яг энэ асуудлаа ярьсаар л байх болно. Юу гэж бодож байгаа юм ер нь.

Ц.Даваасүрэн: Хариулъя.

Д.Эрдэнэбаяр: Нийгмийн асуудалтай холбоотой түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалт орсон байгаа. 1.4.1.5 дээр байна. Мөн Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс бол 330 сумын нийгмийн үйлчилгээтэй холбоотой инженерийн дэд бүтэцтэй холбоотой судалгааг бол 21 аймгийн хөгжлийн бодлогын хэлтэстэй жил болгон хийж индексжүүлдэг. Энэ арга зүйг бол Засгийн газрын тогтоолоор баталсан байдаг. Үүний дагуу эрэмбэ дарааллыг гаргаж тухайн жил болгоны төсвийн төсөвт саналыг хүргүүлж Сангийн яамтай хамтарч явдаг. Хамгийн гол зүйл орон нутагт үйлдвэр, үйлчилгээ бизнес хөгжих тал руу илүү улсын төсвийн хөрөнгө оруулалтыг чиглүүлье гэдэг бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсан энэ тогтоолоос хойш хэрэгжүүлж эхэлж байгаа. Өөрөөр хэлбэл тэнд байгаа иргэдэд ажиллаж амьдрах таатай орчныг нь бүрдүүлэхэд төр улсын төсвөөс хийж байгаа хөрөнгө оруулалтаа хамгийн ашигтай, хамгийн үр өгөөжтэй сумуудад 100-аас 150 км радуст эффект үзүүлэх хамгийн ашигтай байриил руу нэн тэргүүн ээлжид зам татъя. Эрчим хүч татъя. Тухайлбал зам дээр 1300 км замыг бол орон нутгууд руу бүсчилсэн хэлбэрээр татаж байж тэнд борлуулалтаар нь дэмжих ийм зах зээл гадаад дотоод зах зээлтэй холбогдох орон зай бүрдэх юм байна аа. Ингэснээр суманд байгаа иргэдийн үйлдвэрлэл үйлчилгээ ирэх боломж нэмэгдэж байна гэдэг зүйл яригдаж байна. Мөн энэ инженерийн дэд бүтэцд зориулсан 300 сая долларын Азийн хөгжлийн банкны эх үүсвэрийг 17 аймгийн

52 сумд хэрэгжүүлэхээр тусгасан байгаа. Мөн тээвэр ложистикийн шаталсан тогтолцоог орон нутаг руу чиглүүлж байгуулъя гэдэг ийм зорилт мөн туссан байна аа.

Ц.Даваасүрэн: Яах вэ та нар ер нь бас жосоохон тодорхойдуу жил бүр жишээлбэл хэдэн сумыг инженерийн дэд бүтэц, барилга орон сууцын хангамжийн асуудлыг шийдээд явах юм гэдэг ч юм уу нэг иймэрхүү тодорхой хэлэхгүй болохоор ерөнхий ингэх ёстой тэгэх ёстой гэдгийг чинь нээрээ хэдэн арван жил л ярилаа л даа. Тэгж л Батлут гишүүн хэлээд байна шүү дээ. Ингэж битгий яриад байгаач, тодорхой. Энэ жил уг нь 100 сум дээр, 100 тэрбумаар нөгөө 8 айлын орон сууц гээд байсан, тэр яасан? Сангийн яам хариулъя. 100 тэрбум байгаа шүү дээ танайд тэгээд.

Барилгын яамнаас 90-ээд сумын жагсаалт өгсөн. Энэ 100 тэрбумыг тэр 8 айлын орон сууцын санхүүжилтэд ашиглах юм уу, инженерийн дэд бүтэцэд нь ашиглах юм уу. Энэ яг юу болсон. Ингэж тодорхой ярья. Тэгээд ирэх жил хэдэн сумыг инженерийн дэд бүтэцтэй холбох юм. Хөрөнгө оруулалтыг нь хийх юм? Яам хариулъя. Хэдэн номерын микрофон дээр хариулах юм. 1-ийг өгөөд үз дээ.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Энэ жилийн хувьд нийтдээ 98 тэрбум төгрөг Сангийн сайдын багц дээр. Яг дэд бүтэц гэдэг агуулгаар. Тэгэхдээ бол дамжуулан зээл олгоно гэсэн байдлаар бол эдийн засгийн ангиллаар суучхаад байгаа юм. Гэхдээ яах вэ өнөөдрийг хүртэл бол яг бодит нөхцөл байдал дээр энэ зарцуулалт бол гарахгүй байгаад байгаа юм. Зээлийн асуудал байгаа учраас. Тэгээд бидний ойлгосноор бол энийг бол Барилгын яаман дээрээс концепцоо гаргаж ирээд яг орон сууцжуулалтын энэ асуудлаа яаж шийдвэрлэх вэ гэдгээ гаргаж ирээд одоо

энэ төсвийн тодотгол дээр энийгээ барилгын яаманд шилжүүлж өгөөд тэндээ бодлогоо гаргасных нь дагуу зарцуулагдаад явна гэсэн тийм бид ойлголттой байгаа. Тэр дагуугаа зохицуулалт хийчихвэл.

Ц.Даваасүрэн: Одоо яг төсвийн тодотгол дээр эдний багц руу шилжчихсэн байгаа юу?

М.Санжаадорж: Шилжээгүй байгаа санал гарна гэж ойлгож байгаа дарга.

Ц.Даваасүрэн: Хэн гаргах юм? Одоогийн бид нар чинь өчигдөр та нартай хуралдаа суусан. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр байхгүй байгаа шүү дээ.

М.Санжаадорж: Ажлын хэсэг дээр л гарна гэж бид хэд ойлгоод явж байсан.

Ц.Даваасүрэн: Үгүй үгүй бид нар яаж та нарын тэрийг мэдэж яах вэ дээ. Тэгэхээр өнөөдөр тэгвэл ажлын хэсэг рүү Сангийн яамныхан энэ саналыг хүргүүлээд тэр багцаас багц шилжүүлэх арга хэмжээг нь авчих. Тэгэхгүй бол та нар төсвийн зээл гээд л тэгнэ. Тэр зээлийг чинь хэн ч авахгүй тэгээд 98 тэрбум чинь буцах гээд байгаа учраас тийм зарцуулалт наадхыгаа бодитой ажил хэрэг болгохын тулд тэр холбогдох яам руу шилжүүлчихье за юу. Нэг ийм ажил хийгдэх юм байна шүү Батлут гишүүн ээ.

Заяабал гишүүн асуултаа асууя.

Б.Заяабал: Өдрийн мэнд хүргэе бүгдэд нь. Тэгэхээр энэ 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 4 жилийн Монгол Улсын хөгжлийг тодорхойлох ийм том бодлогын баримт бичиг орж ирж байгаа юм. Энэ 4 жилийн хугацаанд энэ бүрэн эрхийн энэ парламентын 4 жилийн хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнд ямар ямар ажил хийгдэх вэ? Энэний үр

дүнд Монголчууд Монголын ард иргэд өрх айлд ямар зэрэг эерэг нөлөөллүүд бий болох вэ? Монгол хүний амьдралын чанар хэр зэрэг дээшлэх вэ гэдэг нь энэ бодлогын үр дүнгээр тодорхойлогдох ёстой юм аа. Тэгэхээр энэ дээр бол эдийн засгийн гол ойлголт бол энэ эдийн засгийн өсөлтийг хангах тогтвортой авч явах гэдэг бол хамгийн гол ойлголт байгаа. Эдийн засгийн өсөлтийн хамгийн гол бас нөлөөлөх гол үзүүлэлтийн нэг нь бол энэ экспорт, импортын зөрүү буюу энэ гадаад худалдааны тэнцэл хамгийн чухал. Ер нь хөгжссөн орнуудыг аваад үзэхэд бол ер нь экспорт чиглэлтэй ийм үйлдвэржсэн орнууд л өндөр хөгжилтэй орнууд байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нар бас энэ экспорт тал дээрээ ер нь илүү их онцгой анхаарах хэрэгтэй байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг ч гэсэн өсөлтийн он жилүүдийг ч гэсэн аваад үзэхэд энэ экспорт өндөр байсан гадаад худалдааны тэнцэл ашигтай байгаа ийм цаг үе дээр бас Монгол Улсын эдийн засаг өсөлттэй гарч явдаг. Ингээд Монгол Улсын экспортыг аваад үзэхээр зэрэг гол нэр төрлийн эрдэс баялгийн зэс, нүүрс гэсэн 2 том металл дээр л ашигт малтмал дээр л ингээд тогтож байгаа юм.

Тэгэхээр эдийн засгийнхаа өсөлтийг бид нар хангахын тулд зөвхөн энэ эрдэс баялгийн бүтээгдэхүүнүүд дээр тогтох биш бусад үйлдвэрлэлүүдийг хөгжүүлэх ийм зайлиггүй шаардлага байгаа юм аа. Шаардлага байгаа. Энэний төвд энэ бизнес эрхлэх энэ таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх ийм бодлогыг энэ 4 жилийн бодлогын гол бүрэн баримт бичиг болгож оруулж ирэх ёстой гэж ингэж миний хувьд харж байгаа юм. Энэ дээр би энэ дээрээс холбоотойгоор энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөс асуух гээд байгаа юм аа. Бизнес эрхлэхэд хамгийн чухал зүйл бол өнөөдөр яг ард иргэдийн ярьж байгаа гол хүсэж байгаа гол зүйл энэ хямд эх үүсвэртэй зээл олдоц хүрэлцээтэй зээлийн асуудал яригдаж байгаа. Энэний цаана банкны реформын

асуудал яригдаж байгаа. Зээлийн хүүг бага байлгахтай холбоотой асуудал яригдаж байгаа. Зорилтот түвшин ярихад би бас энэ дээр ярина. Зорилтот түвшин дээр та бүхэн тодорхойлж оруулж ирэхдээ инфляцыг хамгийн доод тал нь 5 хувь байна гээд ингээд тогтмол инфляцтай инфляцыг бас өндрөөр ингэж тодорхойлж оруулж ирсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр энэ банкны салбар зээлийн бодлого дээрээ ямар бодлого байгаа юм бэ гэдэг 1 дүгээр асуудал.

2 дугаарт нь бизнес эрхлэхэд гол чухал бодлогын нэг нь бол энэ татварын зохицуулалтын асуудлууд байгаа. Би нэг минутаа үргэлжлүүлээд бас аваад явчихъя. Татварын зохицуулалтуудын асуудлууд байгаа. Ингээд бас 3 намын.

Ц.Даваасүрэн: Нэг минутыг нэмээд өгчихье. Заяабал гишүүний. Ингээд 3 намын гэрээ байгуулагдсан байгаа. Энэ дээр бол 3 намын мөрийн хөтөлбөрт туссан гол гол бодлогууд тусгаад явж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Ингээд энэ татварын зохицуулалттай татварын дэмжлэгийн бодлогууд бас энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр бас бүрэн тусгагдаагүй байна аа. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжинэ гэсэн ийм бодлого явж байгаа боловч нөгөө нэг Ардын намын хөтөлбөр дээр байгаа нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг 400 сая болгоно гэсэн энэ бодлого чинь бас орж ирээгүй байгаа. Бусад энэ намын мөрийн хөтөлбөр дээр тавигдсан ААНОАТ-ыг хөнгөлөхтэй холбоотой заалтууд, бүсчилсэн татварын бодлогын асуудлууд гэх мэтчилэн ийм бодлогууд бас бүрэн тусгагдаагүй байгаа. Энэ дээрээ бас тодорхой нэмэлт мэдээллийг өгөөч гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Эдгээр ороогүй байгаа зарим мөрийн хөтөлбөр дээр туссан заалтуудыг бас нэмж оруулах бас ийм саналтай байгаа гэдгийг бас энэ даширамд бас хэлье ээ.

Мөн энэ бүс орон нутгийг хөгжүүлэхтэй холбоотой бодлого бол энэ тусгай бүсүүдийг зарлаж хөгжүүлнэ гэдэг ийм зүйлийг ярьж ирж байгаа. Өмнө нь бид нарын хөгжүүлж ирсэн энэ чөлөөт бүс гэсэн ухагдахууныг бид нар хэрэглэж ирсэн. Чөлөөт бүс гэхээр бид нар энэ хилийн ойролцоо байдаг гэдэг ийм ойлголттой. Өнөөдрийн байдлаар энэ чөлөөт чөлөөт бүс чинь ерөөсөө л нэг архи тамхи зардаг ийм л худалдаа эрхэлдэг ийм бүс болж хувирсан. Одоо ингээд тусгай бүсүүдийг зарлана гээд ингээд орчихсон байгаа. Энэ дээрээ бас энэ тодорхой мэдээлэл өгөөч гэдэг ийм хүсэлт байгаа юм аа.

Дараагийн асуудал нь энэ орлогын тэгш бус хуваарилалтыг бид нар бас онцгой анхаарах шаардлага байна гэж ингэж үзэж байгаа. Иргэдийн энэ бид нар энэ орлогын асуудлыг орлого аягүй бага байна. Зарлага нь орлогоосоо өндөр байна. Тийм учраас иргэдийн банканд байгаа зээлийн хэмжээ өндөр байна гэдэг ийм зүйл яригдаж байгаа. Ялангуяа ядуурлын түвшин сая гарсан. Баруун бүс нутаг дээр ядуурлын түвшин 36 хувьтай байгаа. Энэний цаана ерөөсөө л үнийн өсөлт байгаа. Засгийн газар орлого талыг нэмэгдүүлнэ гэдэг боловч яг энэ хэрэглэгчийн сагсны зарлагын тал.

Ц.Даваасүрэн: Хариулъя. 6 номерын микрофон.

Л.Энх-Амгалан: Эдийн засгийн хөгжлийн яамнаас Энх-Амгалан. Заяабал гишүүний зээлийн хүүг бууруулахтай холбоотой асуултад хариулъя.

Зээлийн хүүг бууруулах асуудал бол үндсэндээ 3 асуудлын хүрээнд хөтөлбөр туссан байгаа. Нэг нь банкны зах зээлд хэрхэн өрсөлдөөнийг бий болгох вэ гэдэг асуудал. Энэ дээр гадаадын төрөлжсөн банк, гадаадын банкны салбар, эдийн засагт банкны салбарт орж ирж үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой заалт болсон.

Энэний үр дүнд банкны салбарын өрсөлдөөн нэмэгдэж зээлийн хүү буурах нөхцөл бүрдэнэ.

Хоёр дахь нь бол инфляцыг бага байлгах асуудал. Одоо сая 6 сард батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хууль дээр бол инфляцыг үе шаттай бууруулж 3 хувьд хүргэнэ гэсэн заалт орсон байгаа. Гэхдээ энэ хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний салбар бас ХАА-н салбар хэд хэдэн салбаруудад либералчлал буюу үнэ чөлөөлөх тариф чөлөөлөх асуудлууд тусгагдсан. Эдгээртэй холбоотой инфляц дээр шууд болон дам нөлөөний дарамт орж ирнэ. Ингээд энэ хөтөлбөрийн хүрээнд бид инфляцын зорилтыг 5 хувиас бага түвшинд байлгах тийм агуулгаар бэлдэж оруулсан байгаа. Инфляцыг 5 хувиас бага байлгаж байж цаашдаа зээлийн хүү буурах нөхцөл бүрдэнэ гэдгийг хэлье. Инфляцыг 5 хувиас бага байлгахад бол хөдөө аж ахуйн салбарын хүнсний нийлүүлэлтийн асуудал, тээвэр логистикийн асуудал, мөн эрчим хүчний хангамжийн асуудлууд яригдана. Энэ бүх асуудлуудыг залруулахтай холбоотой зохицуулалтуудыг энэ хөтөлбөрт тусгасан байгаа.

Мөн зээлийн хүү буурахад Засгийн газрын зээлжих зэрэглэлийн асуудал яригддаг. Энэний цаана нь макро эдийн засгийн тогтвортой байдлын асуудал яригдана. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад бол мөн ялгаагүй эрчим хүчний хангамжийн асуудал, хөдөө аж ахуйн салбарын зөв бодлогын асуудал эдгээрийн үр дүнд эдийн засагт төрөлжилт бий болно. Ингэж байж тогтвортой байдал тууштай хангагдана. Эрдэс баялгаас хараат байдал багасна гэдэг ийм концепцын хүрээнд арга хэмжээнүүдийг төлөвлөж оруулсан байгаа. Мөн тэр орлогын тэгш бус байдал, ядуурал, үнийн өсөлттэй холбоотой асуудал дээр хөтөлбөрт бол ядуурлыг 2 дахин бууруулах зорилт тавьж оруулсан. Энэний цаана бол ажил

эрхлэлтийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал яригдана. Одоо манай улсын ажиллах хүчний оролцооны түвшин нэг 59-өөс 60 хувьтай байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр ажил хийх боломжтой 100 хүний 60 л ажил хийдэг гэсэн үг.

Тэгэхээр энэ бол дэлхийн дундаж улсуудын дунджаар нэг 65-аас 70 хувьтай байдаг. Ажил хийх боломжтой хүний 65-аас 70 нь ажил хийдэг гэсэн үг. Гэтэл манай улсад бол 60.

Ц.Даваасүрэн: Тодруулах уу? 1 номерын микрофон. Нэмэлт хариулт өгөх юм байна.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Заяабал гишүүний асуултад хариулъя.

Мөрийн хөтөлбөр дээр таны асуусан яг жижиг, дунд болон гарааны бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэг оновчтой болгож татварын орчныг сайжруулна гээд 3.2.1.3 дээр бол заасан. Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг бид анхааралтай судалж байгаа. Энэ дээр мөрийн хөтөлбөр дээр бид яг тусгайлсан тоо аль болохоор бас энэ Засгийн газрын том бодлогын чиглэл учраас НӨАТ-ын босгын хувьд бол НӨАТ 2 талтай болчихоод байгаа.

Нэгдүгээрт нь бүх нийтээрээ НӨАТ төлөгч болоод И баримт өгдөг больё гэдэг нэг ийм санал гарч байна. Нөгөө талдаа НӨАТ төлөгчийн босгыг нэмэгдүүлээд жижиг дунд ААН-үүд НӨАТ-ын тайлан гаргахгүй бол гээд энэ 2 хоёулаа сөрөг, давуу талтай байгаа. Тэгэхээр бид нар яг энэ асуудал дээр судалж байгаад 2025 оны төсөвтэй холбоотой жижиг, дундын бизнесийн татварын орчныг сайжруулах багц арга хэмжээний хүрээнд бас оруулахаар судалж байгаа гэдгийг хэлье ээ. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тодруулах уу Заяабал гишүүн? Тодруулъя.

Б.Заяабал: Тэгэхлээр би сая хэлээд байгаа юм. Өнөөдөр ядуурлын түвшний шинэ юу гарчихсан байгаа. Ядуурлын түвшний орлого гэдэг дээр нэг иргэний хувьд 418 мянган төгрөгөөс бага орлоготой байвал ядуурлын шугамаас доошоо амьдарч байгаа иргэд гэж ингэж тодорхойлно гээд ингээд зачихсан байгаад байгаа. Тэгээд энийг ингээд 1 өрхийг ингээд 4 ам бүлтэй гээд аваад үзэхээр 1.6 сая төгрөгийн орлого болчихоод байгаа юм. Гэтэл нөгөө талдаа зарлагыг нь аваад үзэхээр энэ чинь аягүй өндөр байгаад байгаа юм. Энэ 1.6 сая төгрөгийн орлоготой иргэдийн тоог аваад үзэх юм бол үндсэндээ 4 ам бүлтэй айлын нэг хүн төрийн албанд ажиллаж байгаа нөхцөлд үндсэндээ энэ ядуурлын шугамд чинь ирчхээд байгаад байгаа байхгүй юу. Нөгөө талаараа зарлагын бүтэц нь байна. Ялангуяа баруун аймаг дээр. Би сая хэлсэн ядуурлын түвшин өндөр байна 36 хувьтай гараад ирчихсэн байна гэж. Улаанбаатар хотоос маш өндөр үнэтэй өргөн хэрэглээний бараа хэрэглэж байна. Улаанбаатар хотоос маш өндөр үнэтэй бензин шатахуун хэрэглэж байна. Энэ дээр нөгөө нэг барааны үнэд хяналт тавьдаг ШӨХТГ гээд одоо яг ямар агентлаг байна. Энэ дээрээ Засгийн газрын хувьд бас энэ иргэдийн зарлагын бүтэц дээр ямар бодлого барьж байгаа вэ гэдэг дээр би тодорхой асуулт асуусан. Энэ дээр 1 дүгээрт мэдээлэл авмаар байна.

Хоёрдугаарт нь энэ уул уурхайн салбарыг бас бид нар энэ орлогын тэгш хуваарилалтыг ил болгохтой холбоотой энэ уул уурхайн салбар дээр бас бид нар ил болгох ил тод болгох тал дээр бас онцгой анхаарах ёстой гэж ингэж бодож байгаа. Ялангуяа А лиценз гэж олгодог. Өөрөөр хэлбэл эдийн засгийн харилцаанд иүүд орохыг нь төрөөс зөвшөөрөл олгож байна гэсэн үг. 1700 орчим А лиценз байгаа. Өнөөдөр ашиглаж байгаа үйл ажиллагаа явуулж байгаа 300 орчим нь л

орд байгаа. Үлдсэн нь А лиценз гэсэн нэртэй цаасыг зардаг дамжуулдаг ийм л үйл ажиллагаа явуулж байгаа. Эдийн засгийн эргэлтэд орохгүй байгаа. Энэн дээр Уул уурхайн яам ямар бодлого барьж байгаа юм бэ гэдэг ийм мэдээлэл асуучихъя.

Гуравт нь, хамгийн сүүлд нь энэ хиймэл дагуултай холбоотой мэдээлэл асуумаар байна. Зөвхөн интернэт холбоо гэхээсээ илүү эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр бас энэ хиймэл дагуулыг.

Ц.Даваасүрэн: Хариулъя. Орлогоос эхлээд явчих уу нэг номерын микрофон. Тэр орлогын асуудал дээр нь хариулах уу? Нэг номерын микрофон эхлээд явчихъя. Тэгээд дараа нь 6 номер хариулъя.

Э.Батболд: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам одоогийн байдлаар 1700 орчим А лиценз байна. Тэгээд бид манай яамны зүгээс лицензийг яаж чанартай болгох вэ цаашид яаж багасгах вэ гэж ярьж байна. Бид нар хайгуулын түвшинд илүү их анхаарал хандуулж бодлогын түвшинд хандуулж явж байгаа. Жил болгон 40 тэрбум төгрөг хайгуулын салбарт төсөвт тодотгоод явж байна. Тэгээд ерөнхийдөө бол өнгөрсөн 4 жилийн хугацаанд хайгуулын ажил жоохон зогссон тэр бол ковидтой холбоотой байсан. Одоо хайгуулын түвшнийг энэ төсөвтэй холбоотойгоор нэмэгдүүлбэл лиценз ерөнхийдөө чанаржаад багасна гэсэн ойлголттой байгаа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: 6 номерын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан ядууралтай холбоотой асуултад хариулъя.

Ц.Даваасүрэн: Наадах чинь сонсогдохгүй байна. Энэ ер нь сонсогдохгүй байна шүү. Энэ микрофоныг яамаар юм бэ дээ. 5-ыг өгөөд үзье.

Л.Энх-Амгалан: Заяабал гишүүний ядууралтай холбоотой асуултад хариулъя.

Ядууралд өрхийн бодит орлогыг дэмжих тал дээр бол инфляцыг тогтвортой нам түвшинд барих нь бол хамгийн 1 дүгээрт бодлого гэж тодорхойлж оруулсан. Энэний тулд хийх ажлуудыг түрүүн дурдсан. Ер нь зарлагын бүтэц илүү нөгөө үнийг хязгаарлахтай холбоотойгоос илүү өрхүүдийн орлогыг дэмжих нь л хамгийн дараагийн 2 дахь асуудал байж таарна. Зарлагын бүтэцтэй холбоотой нэг хийж байгаа ажил энэ хөтөлбөрт туссан асуудал бол эмийн үнэ, эмийн чанар, эмийн худалдан авалттай холбоотой нэг асуудал төрсөн байгаа. Ялангуяа хөдөөгийн өрхүүд тэтгэврийн насны өрхүүдийн хувьд бол зарлагад нь нэлээд өндөр жин эзэлдэг асуудал бол эмийн зардал. Тэгээд эм чанаргүй байдаг. Эм үнэтэй байдагтай холбоотой асуудлыг шийдэхийн тулд эмийн нэгдсэн худалдан авалтын тогтолцоо буюу чанартай эмийг нэгдсэн байдлаар хэлцэл хийж худалдан авалт хийх тухай асуудлыг тусгасан байгаа.

Хоёрт, хөдөөгийн өрхүүдийн хувьд ядуурал өндөр байгаа нь бас л зарлагын асуудал биш. Орлого талдаа хязгаарлалт өндөр байгаатай холбоотой гэж харж байгаа. Махны үнийг нөөцийн мах бэлтгэх замаар махны үнийг хязгаарладаг, арьс ширний экспортыг хязгаарладаг, ноолуурын экспортыг хязгаарладаг асуудлууд хөдөөгийн өрхүүдийн орлогыг бууруулж байгаа үндсэн хүчин зүйл байгаа. Зарлага талаас нь хянах, үнэ талаас нь хянахаас илүүтэй орлого олох эх үүсвэрийг нь илүү чөлөөтэй байлгана гэдэг концепцоор арга хэмжээнүүдийг хөтөлбөрт оруулсан байгаа гэдгийг хэлье.

Ц.Даваасүрэн: Түвшин гишүүн асууя. Дутуу хариулсан учраас тодруулъя гэж байна. Заяабал гишүүн тодруулъя.

Б.Заяабал: Миний тэр асуусан лицензтэй холбоотой асуудал бол арай өөр юм аа. А лицензийг олгохдоо энэ эдийн засгийн харилцаанд шууд орохыг нь төрөөс зөвшөөрөл олгож байгаа лицензийн хэлбэр шүү дээ. Гэтэл тэр чинь А лиценз авчхаад үйл ажиллагаа явуулахгүй өнөөдрийг хүртэл бариад яваад байна шүү дээ. А лиценз ч гэсэн цаасаа бариад яваад байна. Эдийн засгийн эргэлтэд орохгүй байгаа. Тэгэхээр энэ дээр ямар бодлого барьж байгаа юм бэ гэдгээ ярьж байгаа юм. Хайгуултай холбоотой асуудлуудыг би ойлгож байгаа.

Хоёрдугаарт өмнө нь бас асуусан тэр тусгай бүсүүдийг зарлана. Зарлаж хэрэгжүүлнэ гэдэг ийм зүйлүүд яриад байгаа. Энэ дээрээ ямар ямар тусгай бүсүүдийг хаана хаана зарлахаар явж байгаа юм бэ. Тухайлбал баруун аймагт ямар ямар тусгай бүсүүдийг зарлахаар бас бодлого тодорхойлж явж байгаа вэ гэдэг дээр бас тодорхой хариулт авмаар байна. Евро Азийн орнуудтай энэ худалдааны хэлэлцээр байгуулсан. Тэрний явц ямархуу байгаа вэ? Их Хурлаар орж ирж батлуулах ёстой гэдэг ийм ойлголттой яваад байгаа тэр үнэн үү? Тэр зөв үү? Одоо яг хаанаа явж байна аа? Солонгос, Хятад улстай бас энэ худалдааны хэлэлцээрүүдийг хийнэ. Тарифын болон тарифын бус хөнгөлөлтүүдийг бас оруулж ирнэ ээ. Нөгөө нэг яриад байгаа орлогын чинь эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэхтэй холбоотой энэ хэлцлүүдийг хийнэ гэдэг ийм бодлого бас тодорхойлогдсон байгаа. Энэтэй холбоотой ямар ажлууд хийгдэж байгаа вэ гэдэг ийм зүйлийг бас тодруулчихъя. Бас цагийг ашиглаад тэр хиймэл дагуултай холбоотой зүйлийг бас асуучихмаар байна аа. Зөвхөн Интернэт холбоо гэдэг агуулгаар биччихсэн байгаад байна л даа. Тэгэхээр энэ хиймэл дагуулыг чинь ашиглаад бид нар энэ ургацыг тодорхойлох хөдөө орон нутагт үйл үйл ажиллагаа явуулж байгаа энэ олборлох үйлдвэрлэлүүдийг жишээлбэл хэчнээн куб метр шорооны ажлыг хийсэн бэ? Хэчнээн хэмжээний баялгийг олж байгаа юм бэ?

Тендерийн ажлуудтай холбоотой барилгын явц ямар байгаа юм бэ гэх мэтчилэн ажлуудыг бас энэ хиймэл дагуулаар дамжуулаад хянаад явах ийм боломжтой гэдэг ийм зүйлийг яригдаж байсан шүү дээ. Энэ чинь бас яг энэ хиймэл дагуулуудын чинь бодлогын цаанаас явж байгаа юу гэсэн ийм асуултуудыг бас асууя. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Хариулъя. Нэг номерын микрофон. Тэгээд Цахилгаан, харилцаа холбооноос хүн байгаа юм байгаа биз дээ. Тэгээд дарааллаад хариулаад яваад байгаарай. Нэг номер, дараа нь 6 номер. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам.

Э.Батболд: Яг эрх зүйн хувьд бид нар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулаад байна. Тэгээд гишүүний асуултад дурдагдсан ашиглахгүй байгаа ингээд хадгалаад байгаа лицензтэй холбоотой асуудлуудыг тэнд шийдсэн төлбөрийг нь өсгөсөн байгаа, 4 дахин. Тэгээд энэ хуулиа бид нар ер нь энэ намар чуулганаар өргөн барина гэж төлөвлөж байгаа.

Тэр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр бүх олборлохоос баяжуулаад тэгээд хаах хүртэл бүх цогцоор нь бид нар хийчихсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Хиймэл дагуултай холбогдолтой 8 номерын микрофон өгье. Нэг номерыг өгье. Энэ 8 номер сонсогдохгүй байна. Нэг номерыг өгчихье.

Ч.Золбаяр: Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Үндэсний хиймэл дагуулын техникийн бичиг баримтыг боловсруулах ажлын хэсгийн ахлагч Золбаяр байна. Гишүүний асуултад хариулъя. Үндэсний хиймэл дагуулын энэ манай яригдаж байгаа төсөл маань бол Харилцаа холбооны хиймэл дагуулын төсөл хэлбэрээр явж байгаа. Ер нь бол хиймэл дагуулын систем

маань нам орбитын, дунд орбитын, өндөр, орбитын гэж 3 ангиллаар явагддаг. Энэ маань жео орбитын буюу 36 мянган км-ийн өндөрт байрлах 10 гегайн багтаамжтай мөн телекомын үйлчилгээ үзүүлэх ийм зориулалттай телеком буюу интернэтийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай ийм хиймэл дагуул байгаа. Энэхүү хиймэл дагуулаар таны асуусан асуултад тандан судалгааны хиймэл дагуул боо лео буюу нам орбит дээр ажилладаг. Энэ нам орбитын хиймэл дагуулын үйл ажиллагаа бол дэлхий нийтэд маш их өргөн хөгжиж байгаа. Энэ дагуудаа бол тандан судалгааны нөгөө камерын хяналт хийдэг таны ярьсан энэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх бол харьцангуй нөгөө комешал байдал руу орчихсон учраас бид нар хялбар байдлаар байгаа бусад байгууллагуудын үйлчилгээг хэрэглэх зарчмаар ажиллах бол бүрэн бололцоотой байгаа. Энэ чиглэлээр тандан судалгааны хиймэл дагуулын чиглэлээр бол Цахим хөгжил, харилцаа холбооны яам ШУА-тай хамтраад хамтраад бас энэ тандан судалгааны чиглэл бас энэ тандан судалгааны чиглэл, уул уурхай, байгаль орчин бусад хяналтын чиглэлээр ажиллах тал дээр тодорхой ажлуудыг эхлүүлээд ингээд явж байгаа. Харилцаа холбооны хиймэл дагуулаар ашиглаад бол тоон мэдээлэл солилцох. Интернэт дээр суурилсан бүх төрлийн технологиуд ашиглагдаж байгаа учраас эцсийн төхөөрөмжийн шийдлээрээ дамжуулаад энэ хиймэл дагуулын сүлжээгээр ашиглаж бид нар бас энэ үйлчилгээнүүдийг бас явуулах бололцоотой. Ганцхан тэр тандан судалгаан дээр гэдэг дээр бол туяаны мэдрэгчүүд болон камерын хяналтын системүүд байх ёстой учраас 36 мянган км-ээс тодорхой хэмжээний камер зураг авч нягталж үзүүлэх, 500-1500 км-ээс үзүүлэх гэдэг 2 нь өөрөө ялгаатай байгаа учраас тандан судалгааны дагуулын асуудлыг бол тусад нь бодож авч үзэж байгаа. Өндрийн хиймэл дагуулын хувьд бол энэ хиймэл дагуул маань 15 жилийн хугацаанд тогтвортой ажиллана. Тэгээд хамгийн сүүлийн.

Б.Түвшин: Түвшин гишүүн асуулт асууя. Та бүгдийнхээ энэ өдрийн амгаланг эрье ээ. Хөдөө аж ахуйн чиглэлийн л асуулт асууя. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй холбогдуулаад ер нь яах вэ манай Монголын хамгийн үнэ цэнтэй зүйл бол нүүдэлчин соёл амьдрал, нүүдэлчин малчдын амьдрал байж байгаа. Тэгээд өнөөдөр малчид бол яг одоо малаа үйлдвэрлэх өсгөх тал дээр нийгмийн үүргээ болон өөрийнхөө үүргээ нэр төртэйгөөр биелүүлж явж байгаа. Гэхдээ үнэхээр яг энэ зах зээлийн тогтолцооноос болоод хамгийн ядуу амьдралтай явж байгаа. Өөрөөр хэлбэл яг тэр малчин хүний орлогыг нэмэгдүүлэх яг эдийн засгийн бодлого ерөөсөө явагдахгүй байна. Бодлого явсан ч гэсэн яг тэр нь бол нөгөө байгаа олохгүй явж байна.

Өнөөдөр үйлдвэрлэл хөгжүүлэх гээд байгаа тэр нөгөө ноос, ноолуур, арьс ширнүүд бол нэг талдаа ихэвчлэн экспорт руу хандсан эрчимжсэн мал аж ахуй руу хандсан. Тэгэхээр яг энэ нүүдлийн мал аж ахуйг тэр чигээр нь явуулах үндсэндээ яг хөдөө аж ахуйн мал дээр үндсэндээ тогтолцооны бодлого хэрэгтэй байгаа юм. Энд засгаас их хэмжээний мөнгө гарахгүй. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотод зах зээл бэлэн байж байна. Сар болгон махыг шинээр нь авч хэрэглэх тухай. Зах зээл нь бэлэн. Малчид бол ерөөсөө тогтолцоог нь шийдээд өгчих юм бол сар болгон малаа нийлүүлэх боломжтой.

Тэгэхээр ерөөсөө нүүдлийн МАА энэ малчдын борлуулалтыг буюу малыг нь орох энэ тогтолцоон дээр бодлогын дэмжлэг оруулаач. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт элдэв 7 аргуудаар үгнүүдээр орчихсон байна лээ. Яг гол үндсэн буюу кластер хөгжих гол суурь чинь бол яг энэ бүтээгдэхүүнийхээ үндсэн гол болох махыг нь бариад тэгээд энэ жишжиг тогтолцоонууд чинь өөрөө дагах юм бол арьс шир, ноос ноолуур, дагавар дайвар бүтээгдэхүүнүүд нь өөрөө хөгжсөөд явчих юм аа. Тэгэхээр энэ тал дээр бол яг

нүүдлийн мал аж ахуйг нүүдлийн чигээр нь сэргээх ямар бодлогууд явж байна. Энийгээ яаж хэрэгжүүлбэ гэж байгаа вэ гэдэг дээр 1 дүгээр хариулт өгөөч.

Хоёрдугаарт яг энэ бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа одоо ялангуяа цалингийн орлогоо нэмэгдүүлэхэд хамгийн их саад болж байгаа зүйл бол нийгмийн даатгал. Ерөөсөө бараг бүх орлогоос нь нийгмийн даатгалыг авдаг болчихсон. Үндсэн ажил авах нь зөв.

Тэгэхээр нийгмийн даатгалын бодлогыг цэгцлэх ямар хөтөлбөрүүд тусгагдсан бэ гэсэн ийм 2 асуултыг асууя?

Ц.Даваасүрэн: Хариулъя 4 номер.

Т.Гантогтох: Түвшин гишүүний асуултад хариулъя. ХХААХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Гантогтох байна. Малчдыг орлоготой болгох түвшинд Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг үргэлжлүүлэх заалтууд орсон байгаа. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг чинээлэг малчин бий болгох, малчдыг орлоготой болгох, анхан шатын үйлдвэрлэлийг бий болгох анхан шатын үйлдвэрлэлээс цаашилаад “хүнсний аюулгүй байдлын хөдөлгөөн”-ийг үргэлжлүүлээд явна аа. Эндээс анхан шатын үйлдвэрлэгч малчид маань шинэ хоршоо хөдөлгөөнөөрөө орлоготой бий болоод цаашид үйлдвэрлэлээр хүнсний аюулгүй байдлын хөдөлгөөн мөн “цагаан алт” гээд Засгийн газар Улсын Их Хурлын 63 дугаар тогтоолтой уялдуулсан ийм цогц үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг тусгагдаад явж байгаа.

Эдгээр юунуудыг цогц үйл ажиллагааг кластераар бий болгох нөхцөл бий болно гэж харж байгаа.

Ц.Даваасүрэн: Өөр нийгмийн даатгалаас. Энэ нийгмийн даатгалаас хүн байна уу? Халамж, гэр бүл, нийгмийн

даатгалын чиглэлийн асуултад хариулъя. Хүнийг нь дуудъя. Санал хураалт байгаа нэг.

Хөдөлмөр нийгэм хамгаалал гэр бүлийн асуудлын яам хуралдаанд оролцъё Энх-Амгалан сайд, Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга энэ чинь 3-ын 3 хүн аль нэг нь ирж болно шүү дээ.

Хөдөлмөр, нийгэм хамгаалал, гэр бүлийн яам руу манайхан холбогдсон юм уу? Хариулах хүнийг нь хурдан дуудъя. Энэ хурал сунжраад байна. Тэр 1 номерын микрофон дээр суучих. Түвшин гишүүн асуулт чинь. Түвшин гишүүн Нийгмийн хамгааллын яамнаас ямар асуулт асуусан бэ гэхээр энэ бизнес эрхлэгч нарт дарамт үзүүлэхгүйгээр таатай байдлаар НДШ-ийн тогтолцоонд ямар өөрчлөлт орж байна гэж асуусан. Энэнд хариулъя. Нэг номерын микрофон тэгээд албан тушаалаа нэрээ хэлээд хариултаа өгье.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Уг зорилт маань голчлон хөлсөөр ажил гүйцэтгэх болон ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээ тэдгээртэй адилтгах гэрээн дээр нийгмийн даатгалын шимтгэл бүтнээрээ ноогдуулж байгаа нь бас ялангуяа богино хугацаанд хөдөлмөр эрхэлж байгаа энэ ажил олгогч болон бусад хүмүүст хүндрэлтэй байна гэдэг саналууд их гарсан. Тийм учраас ер нь цаашидаа энэ хөдөлмөрийн гэрээнээс бусдаар өөр төрлийн гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд зөвхөн тухайн гэрээнийхээ хөдөлмөрийн хөлстэй хэсэгт ноогдох хэсэгт илүү ухаалаг байдлаар бага зардлаас өөрөөр хэлбэл шимтгэл авах чиглэлээр харилцан уян хатан зохицуулалттай байхаар энэ бодлогын зорилтыг оруулж ирж байгаа.

Тэгэхээр тухайн үедээ бол энэ ерөнхий зорилго үйл ажиллагаагаа

хэрэгжүүлэх төлөвлөгөөн дээр нарийн зорилтууд орж ирнэ ээ. Нөгөө талаасаа дэлхий дахинд тулгамдсан асуудал тэтгэврийн сангийн зардал нэмэгдэж байгаа. Монгол Улсад ч гэсэн маш хурдацтай нэмэгдэж байгаа. Нөгөө талаасаа бид нар хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоо руу шилжиж байгаа учраас шилжилтийн зардал тэтгэврийн сан дээр бас нэлээд өндөр орж ирж байгаа. Ийм учраас богино хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэлийг бууруулах боломж маш хязгаарлагдмал ЭМД-ын сан мөн алдагдалтай байдаг. Шимтгэл бууруулах боломж бага. Тийм учраас аж ахуйн нэгжүүдэд дарамт болохгүй байдлаар шимтгэлийг дотоод зохицуулалтуудыг сайжруулах зарим шимтгэл авахгүй байх орлогыг илүү тодорхой болгох гэх мэт өнөөгийн эрх зүйн байдлаар ачаалал нэмэгдүүлэхгүй. Тэгэхдээ харилцан ашигтай байх нөгөө талдаа нийгмийн даатгал төлж байгаа даатгуулагчийн нийгмийн баталгааг бууруулахгүй байх гэсэн энэ зорилтын хүрээнд бас тодорхой байдлаар орлогын бүрэлдэхүүн дээрээ анхаарах мөн нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажил олгогчийн орлогын дээд хязгаарыг бас дахиж авч үзэх гэх мэт энэ асуудлуудаар бас ажиллах зорилгоор энэ зорилгыг оруулж ирсэн гэж үзэж болно. Тэгэхээр Засгийн газар газар дээр тусгай төлөвлөгөө батлагдсаны дараа бас ажлууд нь илүү тодорхой болоод явна аа.

Ц.Даваасүрэн: Би ганц, хоёр зүйл бас тодруулаадахъя. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг ингээд харахаар энэ үйлдвэрлэл бий болох чиглэлд бас тодорхой юм харагдахгүй байгаад байгаа юм. Манайхан чинь эдийн засаг солонгоруулна гээд л яриад л байдаг нөгөө ярьсан хэвээрээ. Тэгэхээр бид нар нэг 15 тэрбум долларын экспортын орлого өнгөрсөн жил гаднаас олсны дийлэнх нь 9 тэрбум нь нүүрс, цаана нь нэг 2 тэрбум гаруй нь алт, зэс. Хөдөө аж ахуй ерөөсөө 1 тэрбум доллар хүрэхгүй үгүйтэй байгаа байхгүй юу. Тэрэн дотроо ноолуур нь 700-

аад сая доллар. Тэгээд ингэхээр жишээлбэл нүүрсний үнэ унаад байгаа энэ үед цаашидаа жишээлбэл уналт юм уу нийлүүлэлт тоо хэмжээ буурах юм бол бид нар маш хүнд байдалд орохоор байгаа юм. Одоогийн төлөвлөж байгаа энэ зүйлүүд мөрийн хөтөлбөрүүд биелэгдэхэд маш хүндрэлтэй болно.

Тэгэхээр энэ эдийн засгийнхаа орлого талд нь орлого нэмэгдүүлэх экспорт нэмэгдүүлэх чиглэлд нь ер нь ингээд манайхан чинь ингээд хувийнхан хийчихнэ гэж ингэж ойлгоод байгаа юм. Үгүй хувийнхан 30 жил чармайгаад чардайгаад нэг иймэрхүү л байгаад байна шүү дээ. Нөгөө л зөвхөн л ноос ноолуураас өөр юм бараг байхгүй. Яах вэ зүгээр сүүлийн жилүүдэд бол мах харин 2022 онд 40 сая долларын мах экспортолж байсан бол өнгөрсөн жил харин 200 сая доллар болж 4, 5 дахин өссөн. Махан дээр харин нэг өсөлт гарсан. Гэхдээ энэ чамлалттай. Урагвай бол хүн амын тоогоор манайтай ижилхэн. Бас л мал аж ахуйн орон. Малын тоогоор манайх илүү. Гэтэл эд нар 8 тэрбум доллар олж байгаагийн 2 тэрбум долларыг мах болон махан бүтээгдэхүүнээрээ олоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нарт хөдөө аж ахуйд боломж байгаа мөртөө ерөөсөө яг ноолуураа хасах юм бол гурван зуухан сая доллар дэлхийн зах зээлээс олоод байна шүү дээ.

Тэгээд энэ чиглэлд ер нь одоо тэр нөгөө арьс ширний үйлдвэр гэдэг чинь бодитой хэрэгжих юм уу яах юм. Яг эдийн засгийнхаа энэ экспортын орлогын төрлийг олируулахын тулд бид нар ирэх 4 жилд яг юу юу хийх юм. Одоо эдийн засгийн энэ төсөв дээр өчигдөр гарч байгаа асуудал уул уурхайн бас олж байгаа орлогын хэмжээ гээд л тэгэхээр л байхгүй болчхож байгаа байхгүй юу. Зөвхөн уул уурхайгаас олох орлоготой тэгээд тавьсан зорилт нь хэрэгжээгүй. Тэгээд энэ чиглэлд та нар ер нь яг юу бодож байна вэ гэж.

Хоёрт одоо ингээд ерөөсөө үйлдвэрлэл нэмэгддэггүй, үйлдвэрлэл байдаггүй халамжийн орон ингээд л байгаад байх уу? 2 их наяд гаруй төгрөгийн халамжтай. 600, 700 сая долларын халамж өгч байгаа бид нар. Энэ нь нэг бол одоо амаар ороод хоол хүнс болоод баас болж байгаа, нэг бол хувцас болоод л урагдаад алга болчихно. Сая Дэлхийн банкны гаргасан судалгаа манай гишүүд харсан байх. Нэг доллароос 22 центийн бодит капитал бий болгож байна гэж байгаа юм. Бусад улс орнуудын дундаж 50 центээс дээш. Тэгээд бид нар зүгээр л ингээд халамжийн улс гэдэг нь ерөөсөө ганцхан энэ. Арментай ижилхэн байгаа байхгүй юу. Нэг тогтворгүй байгаа Арментай ижилхэн байгаа. Тэгээд энэ асуудал дээр бид нар энэ нэг халамжид хамаагүй мөнгөө зараад үйлдвэрлэлийг ерөөсөө дэмжихгүй байгаа энэ юмыг ер нь яах юм бэ? Одоо 700 сая долларыг жилдээ хэрэглээд байна шүү дээ. 70 сая долларын 10 үйлдвэрийг бид нар хэвчхээд байна шүү дээ. 70 сая долларын үйлдвэр гэдэг чинь бол одоо аймаар том үйлдвэр шүү дээ. 10 сая долларын махны үйлдвэр барьж чадахгүй байна шүү дээ Монгол. Аравхан сая долларын. Тэгсэн мөртөө 700 сая доллар хэвээд байна шүү дээ. Халамжид ингээд өгөөд байгаа мөнгөө бид нар ерөөсөө харамсахгүй байгаад байна шүү дээ. Үйлдвэр баригдахгүй, хувийнхан хийнэ гээд хаячихсан. Хувийнхан нь хийхгүй. Яагаад гэвэл манайх зах зээлийн хэрэглээ муутай орон. Хятад, Солонгост гуанз өдөржин ажилладаг бол Монголд яах вэ ганцхан үдийн цайгаар л ажилладагтай чинь ижилхэн эдийн засагтай орон манайх.

Тэгээд энэ чиглэлд бид нар ямар арга хэмжээ авах юм бэ? Энэ халамжийг бууруулж үйлдвэр, ажлын байр тогтмол орлого бий болгодог. Халамжаар яваад байвал ядуурал буурахгүй буурахгүй. 30 жил халамж өглөө. 30 жил хүүхдийн мөнгө тараалаа ядуурлаас гарсан юм байхгүй. Одоо харин ажлын байр бий болгож аав ээж нь тогтмол орлоготой

болох чиглэлд бид нар ямар өөрчлөлт хийх юм. Энэ халамж үйлдвэрлэл 2-ыг яаж солих юм. Энэ дээр одоо ямар арга хэмжээнүүдийг бид нар авахаар төлөвлөсөн бэ гэж. Ингээж явахгүй бол бид нар болохгүй нь. Энэ гурав дахь асуудал. Шинжлэх ухааны одоо энэ шинжлэх ухаант хандлага гэдэг юм манайд судалгаа гэдэг юм байхгүй болчихсон байна. Салбарууд дээр хүрээлэн алга. Салбарууд дээр техникийн шаардлага, норм норматив, дүрэм боловсруулж байгаа юм байхгүй болчихсон судалгаатай. Өнгөрсөн хавар газын машин дэлбэрсэн. Газын машин дэлбэрсэн юугаа ч ойлгоогүй юугаа ч мэдэхгүй байгаа байхгүй юу. Очиж онцгой байдал энэ тэр бүгдээрээ харж зогсож байгаад дэлбэрч байгаа байхгүй юу. Тэр чинь юу вэ гэвэл аюулын ажиллагааны дүрэм бичигдээгүй байна гэсэн үг. Энэ газын машин хэзээ дэлбэрэх вэ хэдэн километр үйлчлэх үү үгүй юу мэдэж байгаа юм байхгүй. Энэ чинь өөрөөр хэлбэл бид нарт тухайн салбарт шинжлэх ухаан байхгүй байна гэсэн үг. Тэрийг судалж байгаа судлаачид байхгүй байна гэсэн үг. Тэгээд бид нар ирэх 4 жилд энэ шинжлэх ухаанч хандлагаар ханддаг болгохын тулд энэ салбаруудад шинжлэх ухааны энэ хүрээлэнгүүдийг бий болгох чиглэлд авч байгаа юм байна уу? Бид нар аюулгүй ажиллагааны дүрмээ бичиж чадахгүй байна шүү дээ судалж.

Тэгээд яг энэ чиглэлээр жишээлбэл бид нар энэ салбар салбаруудад шинжлэх ухаант хандлага судалгааны хүрээлэнгүүд бий болгох чиглэлд төлөвлөж бодитой хийж байгаа юм байна уу? Ингээд мулгуу байгаад байх уу? Зүгээр л ингээд л амаараа яриад л таалагдсанаа аваад байдаг. Судалгааны ямар ч одоо үндэслэлгүйгээр шийдвэрээ гаргадаг хамгийн сайн тайлбарласан шийдлийг авдаг судалгаагүйгээр. Тэгээд энэ техникийн дэвшил хөгжилтэй уялдаж байгаа юм байхгүй. Тэрийг нэвтрээд ороод ирэхээр тэрийгээ судалж байгаа юм байхгүй. Би хэлээд байна шүү дээ норм, норматив шинээр орж ирж байгаа

юмыг дагаад манайд хийгдэхгүй байна. Эрдэмтэн судлаачид байхгүй болчихсон байна тэрийг хийдэг. Энэ 3 чиглэлд ер нь бид нар ямар өөрчлөлт хийх вэ? Ирэх 4 жилд.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас эхлээд хариулъя. 6 номер.

Л.Энх-Амгалан: Экспорттой холбоотой асуудал. Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотой асуултад хариулъя. Эдийн засаг хөгжлийн яам Энх-Амгалан. Экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотой ялангуяа хөдөө аж ахуйн салбарын экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотой хөтөлбөрт туссан гол ажил бол худалдааны хэлэлцээрүүд байгаа. Одоо яг ОХУ Евро Азийн эдийн засгийн комисстой гол нь гол улс нь бол ОХУ. Тэр улстай 375 нэр төрлийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг татвар, импортын тариф, татваргүйгээр экспорт хийх тийм хэлэлцээр хийгээд одоо яг дуусах шатандаа явж байна. Энэ хөтөлбөрт бас энэ хэлэлцээрийг хийж дуусгана гэж оруулсан байгаа. Энэ 375 нэр төрлийн бүтээгдэхүүн бол одоо 55 хувийн тарифтай ОХУ-д экспортлогдож байгаа. 55 хувийн тарифаас болоод экспортод гарч чадахгүй байгаа. Энэ тарифыг 0 болгох хэлэлцээр хийж байгаа. Энэ бол ХАА-н салбарыг экспортыг дэмжихэд хамгийн чухал арга хэмжээ гэж бодож байна. Энийг залгуулаад Солонгос улстай бас худалдааны хэлэлцээр хийх ажил эхлээд 2 дугаар шатандаа явж байна. 2 талд ажлын хэсгүүд ажиллаад ерөнхийдөө бүтээгдэхүүнээ сонгох шатанд явж байна. Бас нэг нь Хятад улстай худалдааны хэлэлцээр эхлэлтийн шатандаа явж байна. Одоо Хятад улстай бол гол хийж байгаа худалдаа нүүрсэн дээр бол манай улс 3, 5 хувийн тарифтай байдаг бол Австрали улс татваргүй байдаг. Энэнээсээ болоод манай улсын бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар унаж байдаг. Ийм асуудал байгаа. Хөдөө аж ахуйн салбарын экспорт Шинэ

Зеланд улс яаж чадаад, манай улс яагаад чадахгүй байгаа юм бэ гэхээр манай улсын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд ихэнх нь татаастай байдаг.

Ноос ноолуур, мах, сүү гээд бүгд татаастай. Энэ татаас байгаа нь өөрөө хөдөө аж ахуйн бизнесийг яг эцсийн экспортын бүтээгдэхүүн хөгжих боломжийг хаачаад байгаа юм. Зүгээр түүхий эд бэлтгээд тэрнийгээ сумдаа бүртгүүлээд тэрүүгээрээ улсаас татаас авах тийм л бизнесийн загвар болчихоод байгаа гэсэн үг. Энэнээс болоод манай улсын хөдөө аж ахуй хөгжиж чадахгүй. Гэтэл Шинэ Зеланд улс яаж чадаад байна гэхээр 1970-аад оноос өмнө Шинэ Зеланд улс яг ийм адилхан татаастай байсан. Тэгээд татаасаа байхгүй болгосон. Татаасаа байхгүй болгосны дараа 3, 4 жил тэр улсын хөдөө аж ахуйн экспорт нэлээд бага байсан. Хөдөө аж ахуйн салбар нь нэлээн хэцүү байсан. Гэхдээ тогтвортой явж чадсанаар хангалттай хэмжээний өнөөдрийн энэ том дүнгээр экспорт хийж чаддаг улс болсон. Шинэ Зеланд улс чадсан 2 дахь шалтгаан нь бол бас Австрали улстай худалдааны хэлэлцээр байгуулсан. Тэрнийхээ үр дүнд хөдөө аж ахуй.../минут дуусав/.

Ц.Даваасүрэн: Нэмэх өөр нэмэх яам байна уу? Би нөгөө халамж үйлдвэрлэл яаж солигдох юм гэж асууя. Сая 6 номер тэрийгээ нэмээд явах юм уу? Одоо ингээд л хэдэн их наядын халамжаа өгөөд л ингээд л яваад л байх уу? тэгээд. Баян айлын хүүхэд нь ч мөнгөө аваад л байж л байдаг. Тэгээд үйлдвэр идээд л байж л байдаг. Энүүгээрээ л байгаад байх уу? Нэг номер.

Дараа нь хүрээлэнгүүд гэж би асуусан шүү дээ. Хүрээлэн чинь Эдийн засгийн яам руу оччихсон юм байна лээ. Тэгээд та нар хариулна шүү нэг номерын микрофон.

Л.Мөнхзул: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд нийгмийн халамжийг зөвхөн зорилтот

бүлэгт чиглүүлнэ гэсэн нэлээн том зорилт орсон. Одоо бол хүүхдийн мөнгийг оролцуулан нийт хүн амын 60 орчим хувь нь халамж авч байна гэсэн ерөнхий тоо. Гэхдээ давхардсан тоогоор. Мөн нийгмийн халамжийн сангийн зардлын бас тодорхой хэсэг нь амьжиргаа сайтай бүлгүүдэд очиж байна гэсэн статистик судалгаа байгаа. Энэний үндсэн шалтгаан нь юу вэ гэхээр бид нар халамжийг олгохдоо орлогод үндэслэсэн байдлаар өрхийн орлого болон иргэний орлогод үндэслэсэн байдлаар бус харин нийгмийн халамжийг олгохдоо хүн амын категори бүлгүүдэд чиглэсэн аргачлалаар олгодог. Тухайлбал хэрэв та ахмад настан бол амралт сувилалд явах эрхтэй. Орлогын үзүүлэлтийг бид нар харгалзаж үздэггүй гэх мэт энэ үзүүлэлтүүд байгаа.

Тийм учраас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ ядуурлын тооцдог өрхийн амьжиргааны түвшинийг тооцдог аргачлалыг Монгол айл өрхөд нийцсэн байдлаар төрийн мэдээлэлд үндэслээд биг дата дээрээ үндэслээд энэ аргачлалаа сайжруулъя орлогыг өрхийн орлогыг бодитой тооцдог болъё. Тэгээд орлогод нийцсэн байдлаар халамжаа зорилтот хэсэг рүүгээ чиглүүлбэ гэсэн зорилтууд үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл дээр орсон байгаа.

Ц.Даваасүрэн: 3 номер хариулъя. Түрүүний хүрээлэнгүүд байгуулах шинжлэх ухаанч хандлагуудыг бий болгох, тэгээд үйлдвэрлэлийг дэмжих чиглэл дээр ямар бодлого оруулж ирээд байгаа юм гээд байгаа юм.

Л.Энх-Амгалан: Эдийн засгийн хөгжлийн яам Энх-Амгалан. Үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой тодорхой төслүүд энэ хөтөлбөрт сууж орж ирсэн байгаа. Нийт 5, 6 шинжлэх ухааны парк хэлбэрээр хөгжүүлэх үйлдвэрлэлийн төслүүд орсон. Энд бол гангийн үйлдвэр байгаа. Ялангуяа барилгын материалын үйлдвэрлэлтэй холбоотой. Кокс химийн үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэр гээд. Энэ

боловсруулах үйлдвэрүүдийг яг шинжлэх ухааны парк хэлбэрээр байгуулахаар концепц нь Эрдэнэс Монгол компани дээр гараад нэлээд хөгжүүлчихсэн явж байгаа. Тэгээд тэр дагуугаа хийж байгуулна гээд энэ хөтөлбөрт тусгаж оруулсан. Энэ нь бас яг өмнөтгөл хөтөлбөрийн өмнөтгөл хэсэгт онцолсон 14 мега төсөл гэдэг дотор бас эдгээр хүрээлэнгүүдийг нэн даруй эхлүүлэх боломж нөхцөлийг хангана гээд онцолж орсон байгаа. Тэгэхээр эдгээр шинжлэх ухааны парк боловсруулах үйлдвэрүүд бол эдийн засгийг нь төрөлжүүлэхэд цаашидаа чухал хувь нэмэр оруулна гэж бодож байна. Шинжлэх ухааны хүрээлэнтэй холбоотой сая Засгийн газрын бүтэц байгуулахад Боловсролын яаман дээр байсныг Эдийн засаг хөгжлийн яаман дээр авчирсан. Энэний цаад санаа нь бол шинжлэх ухааны хүрээлэнгүүдээр хийж байгаа судалгаануудыг эдийн засгийн бодит салбаруудад хэрхэн ашиглах дээр ахиц гаргах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яаман дээр авчирсан. Одоо яг Эдийн засаг хөгжлийн яамны бүтэц хийгдээд хүрээлэнгүүдтэйгээ танилцах тэр шатдаа явж байна. Хөтөлбөрт бол шинжлэх ухааны хүрээлэнгүүдийг яг нэгдсэн цогцолбор байдлаар нэгдсэн бодлогоор зангидаж явна. Нэгдсэн цогцолбор байгуулна гэдэг үг үсгээр хөтөлбөрт туссан. Тэгээд цаашидаа яг эдийн засгийн салбаруудад хүрээлэнгүүдээр хийгдсэн судалгааны үр дүнгүүд хэрхэн ашиглагдах талаар цаашидаа илүү тодорхой болоод явах байх. Тэгээд энэ дээр бусад яам.

Ц.Даваасүрэн: Хөдөө аж ахуйн яам. 3 номерын микрофон.

Тэр 3 номерын микрофон хариулахын өмнө хөдөө аж ахуй татаастай байдаг юм аа. Тэр тэр зургаа буруу яриад байна. Яагаад гэвэл цагаан будаа, улаан буудай, мах бүгд татаастай. Одоо жишээлбэл манай энэ органик мах чинь байна шүү дээ дэлхийн зах зээл дээр 1 кг нь 40 доллар байгаа? Жижиглэнгийн үнэ гэтэл бид нар ард

түмэндээ 40 доллароор зарахгүй шүү дээ. 5 доллароор зарна. Бусдыг нь яах вэ татаасаар өгнө. Яваандаа тийм болно. Энэ бусад улс орнууд тийм байгаа. Дотоод зах зээлдээ татаас өгч байгаа. Гадагшаа зах зээлдээ дэлхийн зах зээлийн үнээр нь гаргаж байгаа. Тийм учраас би татаасгүй хөдөө аж ахуй гэж ерөөсөө сонсоогүй юм байна. Улаан буудай, цагаан будаа, мах энэ бүгд бүгд татаастай байдаг. Ногоо ч гэсэн, хүнсний ногоонууд байна. Ихэвчлэн татаастай байдаг. 3 номер.

Т.Гантогтох: Даваасүрэн даргын асуултад хариулъя. ХХААХҮЯ-ны Хяналт-шалгалт, дотоод аудитын газрын дарга Гантогтох байна. ХАА-н бүтээгдэхүүний экспорт нэмэгдүүлэх асуудлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ерөнхийдөө суурь түвшин болон бэлтгэн нийлүүлэгчид болох шинэ хоршоо малчид тариаланчдаа дэмжих чиглэлээр шинэ хоршоо чинээлэг малчин хөтөлбөрийг оруулсан байгаа. Мөн атрын 4 дүгээр аяныг үргэлжлүүлэх цаашидаа энэ газар тариалангийн үйлдвэрлэлийг 200 га-гаар нэмэгдүүлэхээр тусгагдаад явж байгаа. Энэтэй холбогдуулаад үйлдвэрлэлийн салбар болох хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох хүнсний аюулгүй байдлын 36 дугаар тогтоолыг үргэлжлүүлэх чиглэлээр бас заалтууд ороод явж байгаа. Энэ дагуу экспортыг нэмэгдүүлэх мөн цагаан алт хөтөлбөрийн хүрээнд хөнгөн үйлдвэрийн салбарын малын гаралтай бүтээгдэхүүнүүдийн экспортыг нэмэгдүүлэх энэ зохицуулалтууд энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт суугаад явж байгаа. Ерөнхийдөө Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Монгол малын махыг брэнд болгож экспортод гаргах тал дээр ихээхэн анхаарал хандуулъя гэж явж байгаа. Энэний гол үндэс болох малын өвчлөлийн асуудал байгаа. Малын эрүүл мэндийн асуудал байгаа. Энэ дээр анхаараад дэлхийн мал эмнэлгийн байгууллагатай гоц халдварт өвчний хорионд орсон энэ өвчлөлүүдийнхээ тал дээр анхаарч ажиллана гэсэн байгаа.

Энэтэй холбогдуулаад тусгаарлах бүсүүдийг бий болгох мөн энэ био кабинетын шинэчлэлийг хийгдэх энэ вакцины асуудал дээр анхаарч ажиллахаар энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр тусгагдаад явж байна аа. Мөн цаашилаад үйлдвэрлэлийн хувьд гэвэл Дархан арьс ширний цогцолбор буюу одоогоор хийгдэж байгаа ажлыг хөнгөн үйлдвэрийн цогцолбор Дархан хөнгөн үйлдвэрийн цогцолбороор мөн арьс шир гэхгүйгээр ноос ноолуурын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх мөн Эмээлтийн аж үйлдвэрийн цогцолбор хотод баруун бүсэд аж үйлдвэрийн цогцолборуудыг хийхээр явж байгаа. Мөн сүүлийн таны асуусан асуултад шинжлэх ухааны.

Ц.Даваасүрэн: Салбарууд дээр хүрээлэнтэй байх тухай л яриад байгаа шүү дээ би. 3 номерын микрофоныг.

Т.Гантогтох: Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын хувьд яалт ч үгүй бас энэ үйлдвэрлэл шинжлэх ухааны хувьд салангитай явж байсан. Ийм гажуудал байгаад байгаа. Тийм ч учраас энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр энэ шинжлэх ухаанчаар цаашдынхаа үйлдвэрлэлийг энэ хэрэглэгчдэд хүргэх энэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлүүдээ явуулья гэдэг төлөвлөлтөөр явж байгаа. Энэ хүрээнд ч гэсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгийн 3.5.6 дээр Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан судалгаа хөгжлийн төвийг байгуулж ХХААХҮ-ийн салбарыг үе шаттайгаар хөгжүүлнэ, нийлүүлнэ гэсэн ийм юутай байгаа. Тийм ч учраас энэ хүрээлэнгүүдээ бас энэ Боловсролын яамны харьяанд байдаг хүрээлэнгүүдийг тухайн салбарынхаа үйлдвэрлэлтэй ойрхон байгуулах энэ эрдэмтэн судлаачдыг бас тодорхой хэмжээгээр үйлдвэрлэлд үе шаттайгаар ингэж оруулдаг байх ийм бодлогыг хэрэгжүүлэхээр энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаад ажиллаж байгаа.

Ц.Даваасүрэн: Хөдөө аж ахуй дээр хамгийн гол юм мал эрүүлжүүлэх асуудал. Тэгээд тэр нөгөө ээмэгжүүлэх хариуцлагажуулах асуудал байгаа шүү дээ. Тэр энэ тэрийгээ л сайн хийх хэрэгтэй. Хүрээлэнг би зүгээр салбаруудыг шинжлэх ухаанч хандлагатай болгоо. Судалгаатай болгоо. Энэ хоцрогдчихлоо. Сүүлийн 30 жил юу ч хийгдсэнгүй. Норм нормативаа боловсруулахгүй байна, стандартаа боловсруулахгүй байна гээд байгаа юм. Тэрнээс биш тэр салбарын стандарт, норм норматив, техникийн шаардлагыг Эдийн засгийн хөгжлийн яам хийж чадахгүй шүү дээ. Тэр салбарууд нь л өөрсдөө хийнэ. Эрчим хүчнийх нь эрчим хүчин дээрээ барилгынх нь барилга дээрээ, хөдөө аж ахуй нь хөдөө аж ахуй дээрээ л хийгээд явна. Тэрийг нь байхгүй болгоод хаячихсан байхгүй юу 1990 онд.

Тийм учраас өнөөдөр энэ бүх салбарууд чинь нефт нь дэлбэрч байхад юугаа ч мэдэхгүй аюулгүй ажиллагааныхаа дүрмээ ч бичиж чадахгүй байгаад байна шүү дээ. Тэрийг яриад байгаа юм би. Ингээд гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулаад асуулт асууж дууслаа.

Асуулттай холбогдуулаад саналтай гишүүн байвал саналаа бичгээр ирүүлж болно. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн байвал нэрээ өгье. Үг хэлэх гишүүн байна уу? Үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулаад. Мөнхсоёл гишүүнийх. Мөнхсоёл гишүүнийх яагаад орохгүй байна? Нөгөө кноп чинь тийшээ орохгүй байна. Энэ чинь нөгөө үг хэлэхдээ заавал дарааллаараа хэлнэ шүү дээ. Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Ганзориг гишүүн үгээ хэлье.

Л.Ганзориг: Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр энэ хот төлөвлөлттэй холбоотой нэг заалт орсон юм. Нийслэлийн Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

2040-ийг боловсруулж батлуулна гээд. Тэгээд ер нь бид нарт тулгамдчихаад байгаа том асуудлын нэг бол энэ хот төлөвлөлт замбараагүй явснаас болж түгжэрэл, утаа, агаар хөрсний бохирдол гээд олон асуудлууд хуримтлагдсан байж байгаа. Тэгээд энэ хот төлөвлөлтийн асуудлыг ярихаар зөвхөн ерөнхий төлөвлөгөө гээд нийслэл нь ч байна уу, дүүргүүд нь ч байна уу ингээд төлөвлөгөөгөө баталчхаад тэрийгээ ингээд хот төлөвлөлт гэж ойлгоод яваад байдаг. Гэтэл газар зохион байгуулалтын төлөвлөгөө гэдэг аягүй чухал асуудал байгаад байдаг. Газар олголт гэдэг асуудал байгаад байдаг. Энэ нь ямар ч хот төлөвлөлттэйгөө уялдаагүй явж ирсэн энийгээ цэгцлэхгүй бол болохгүй нь ээ. Тэгээд энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр энэ газар олголтын асуудлуудыг Газрын багц хуулийн асуудлуудыг яах вэ Газрын багц хуулийн асуудлыг товчхон оруулчихсан байна лээ. Нэлээн тодорхой оруулж ингэж явахгүй бол одоо өнөөдөр бид нар төсвийн тодотголоор газар чөлөөлөлтөд 550 орчим тэрбум төгрөг тавьчихсан сууж байгаа шүү дээ. Нийслэлийн Засаг дарга байна уу дүүргүүдийн дарга нар байна уу шат шатын энэ удирдлагууд өөрсдөө газраа олгодог. Буцаагаад төсвийн мөнгөөр хэдэн зуун тэрбумаар нь худалдаж авч ингэж бүтээн байгуулалтаа хийх ийм хачин тогтолцоо руу явчихсан байж байгаа. Саяхны жишээ хэлэхэд шинэ суурьшлын бүс Хөшигтийн хөндийд нэг хүн 500 орчим га газартай, тэрийгээ буцаад бас төсвийн хөрөнгөөр олон 10 тэрбум төгрөгөөр буцааж улсад нөхөн төлбөртэйгээр өгөх асуудал яригдаж байсан.

Тэгэхээр энэ газрын реформ газар олголтын асуудал, газрын багц хуулийн асуудлуудыг нэлээн сайн тусгаж явахгүй бол энэ цаашаага улам даамжрахаар байна зүгээр. Сүүлийн бас 2, 3 жилийн жишээ энэ Нийслэлийн төсөв дээр харахад л нийслэл дээр жил болгон л 100 гаруй тэрбум төгрөг тавьж байгаа шүү дээ. Газар чөлөөлөлт дээр. Тэгээд тэр нь

ил тод нээлттэй биш. Ямар байдлаар үнэлж хэдэн нэгж талбар газрыг ямар хүнээс яаж авч байгаа нь тодорхойгүй. Тэр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө бол энэ газрын холбоотой асуудлуудыг л тодорхой тусгаж явахгүй бол энэ төсөв дээр яваандаа энэ газар чөлөөлөлтийн зардал гэдэг аягүй том зардлууд дарамт болж орж ирэхээр байна шүү гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Батлут гишүүн үгээ хэлье ээ. Тэр 2040-тэй холбогдолтой манайхан тэмдэглэж аваарай. Ер нь бас ингээд харж байхад энэ Нийслэлийн иргэдийн хуралд сууж байсан улсууд энэ тэр аймгийн удирдлагууд энэ тэр Их Хуралд орж ирэхээр бас юманд арай өөр байна шүү. Хандлага өөр. Юу асуух юу ярихаа маш сайн мэдэж байна. 2040-ийн асуудлыг үнэхээр анхаарахгүй бол нийслэл 2 жил төлөвлөлтгүй явж байгаа шүү. Энийг сайн тэмдэглэж аваарай. Тэгээд Батлут гишүүн.

Д.Батлут: Асуусан асуултынхаа дагуу үг хэлье ээ. Ер нь ингээд хөдөөгүүр явж байхад, манай энэ яам, Тамгын газарт, Засгийн газарт ажиллаж байгаа хүмүүс ширээний ардаас гаралгүй их удсан юм байна. Тэгээд амьдрал дунд ерөөсөө ороогүй юм байна. Тэр нь ингээд л өнөөдрийг хүртэл ингээд явчхаж. Тэгэхээр бид нар дандаа буруу төлөвлөлт хийсэн гэсэн үг. Тэр нөхцөл байдлыг мэдээгүй, мэдэхгүй байгаа учраас. Магадгүй нэг утсаар нэг статистик мэдээллүүд л авдаг байх л даа. Мэйлээр ч юм уу. Тэгээд тэр статистик мэдээллүүд нь яаж гарч байгаа ч юм бүү мэд шүү дээ. Яг үнэндээ би хэрхэн цуглуулдгийг нь бас мэднэ. Тэр доод шатанд ажиллаж байсан учраас. Тэгэхээр бүгдээрээ нэг зүйл дээр төвлөрмөөр байна. Хамаг бүхний учиг холбоос юу вэ гэвэл хөдөө суманд ажиллаж байгаа, амьдарч байгаа хүмүүсээ хэрхэн дэмжих вэ гэдэг асуудлыг маш тодорхой гаргаж ирэх хэрэгтэй.

Хүний нөөцийн асуудал, тэнд ажиллах эмч, багш одоо сүүлдээ хүн

өвдөхөд аймгийн төв рүүгээ очиж эмчилдэг болох гээд байна шүү нөхөд өө. Ийм хэмжээнд оччихсон. Тэгэхээр суманд ямар хүний эмч дутагдалтай байгаа, тэрийг хэрхэн бэлдэх вэ, яаж дэмжих вэ, цалин хөлс, нийгмийн баталгааг нь яаж авах вэ гэдэг дээр бүүр тодорхой бодлого гаргаж ирмээр байна. Багш мөн адилхан. Тэнд сайн багш байвал хүүхдүүдээ аваачиж сургана. Төрийн албан хаагч ч гэсэн.

Хоёрдугаарт нь сумдад амьдрах орчныг сайжруулъя. Амьдрах орчныг. Тэнд дэд бүтэц татаад өгчихье л дөө. Халуун бохир цэвэр устай нь. Юу их орох вэ дээ цөөхөн хэдэн төгрөг л орно. Дахин төлөвлөлт хийгээд ингээд. Одоо манайхан нэг зүйл ярьж байгаа юм. 100 айлыг ингээд эрчим хүчээр холбоно дэд бүтэцтэй холбоно ч гэнэ үү. Улсын төсөв иргэн бүрд ижил тэгш хүртээмжтэй хүрдэг байх ёстой. Бүх сумдтай ижил тэгш хөрөнгө оруулалт хийхийг зорих хэрэгтэй. Манайхан яадаг вэ гэхээр дарга дагасан төсвүүд оруулж ирдэг. Тэр сонголт нь болохоор дандаа дарга нарын яах вэ харьяа сумдууд очдог гэсэн үг. Энийгээ л больчих хэрэгтэй. Тэгээд яах вэ бүх сумдаа ижил тэгш тэнд ямар хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байгаа гэдгийг судалж гаргаж ирээд дэс дараалалтай хөрөнгө оруулалтыг хийдэг больё.

Гуравдугаарт нь сумдад бизнес хийх боломжуудыг нэмэгдүүлъя. Улаанбаатар хотод 6, 8 нэрийн дэлгүүр ажиллуулж байгаа хүмүүс 10 хувийн татвар төлж байна, НӨАТ төлж байна. Суманд бас адилхан төлж байна. Зах зээл нь ямар билээ гээд нарийн ширийн бодох зүйлүүд зөндөө байгаа. Энэ бүх зүйлийг л бүгдээрээ нэг шинэ сум гэдэг юм уу юу гэдэг юм ингээд томьёолоод нэг яг бодлогоор бодитой хөрөнгө оруулалтуудыг бодлогын шийдвэрүүдийг гаргаж өгье өө. Энэ чинь нөгөө хүний хөгжлийн гол суурь зарчимд томоохон нөлөөлөл үзүүлэх үр дүнтэй хөрөнгө оруулалт болно. Нөгөө хот төвлөрөл

түгжрэлд чинь тодорхой хэмжээгээр саарна шүү гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь бизнес эрхлэх боломж гэж байгаа. Бид нар ЖДҮ-лэл гэж зөндөө л ярьсан. Бичил бизнес эрхлэгч гэдэг зүйлийг мартчихсан. Өрхийн бизнес эрхэлж, өөртөө ажлын байр гаргах гээд байгаа хүмүүсийг мартчихсан байдаг. Тэр хүмүүсээ бодлогоор, технологиор, бас гоё дэмжиж өгвөл маш том боломжууд хөдөө орон нутгуудад байгаа. Тэгэхээр үүн рүү чиглэсэн төлөвлөлтүүдийг хийж өгөөч гэдгийг бас хэлмээр байна аа.

Эцэст нь энэ Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд болсон Улаанбаатар, Шар хөтөл, Эрдэнэтийн 100 км авто замыг энэ төслийг 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах саналыг гаргаж байгаа зарчмын зөрүүтэй санал байгаа. Дарга энэ боломжтой юу? Яах вэ энэ жил хөрөнгө оруулалтууд нь эхлээд явж байгаа л даа. Тэгээд заавал оруулаад өгөх нь илүү тийм баталгаатай байх гэдэг утгаар нь би байгаль аялал жуулчлалын төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс хэсгийн 1.1.3.3-д энэ төслийг оруулъя гэдэг саналтай байна аа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тийм саналыг хураалгана хураалгана. Батлут гишүүний хэлээд байгаа бас үнэн шүү. Өнөөдөр социализмаас бидэнд нэг маш сайн үлдсэн юм бол захын цэгтээ сургууль, эмнэлэг, цэцэрлэгтэй байгаа байхгүй юу. Тэр Африк, Араб, энэ Азийн орнуудын энэ ялангуяа хөгжиж байгаа орнуудад бол захын цэгтээ ийм капиталын сургууль эмнэлэг байхгүй шүү. Та нар Америк, Европ зөндөө явж үзсэн. Тэнд ийм капиталын цэцэрлэг байхгүй шүү тэгэхээр ийм бидний нэг бий болгосон энэ ололтоо иргэдээ эрдэм боловсролтой эрүүл байлгаад байгаа энэ юмнуудаа л нураачихгүй байя гээд байгаа энэ санал маш чухал.

Да.Цогтбаатар гишүүн үг хэлье.

Дав.Цогтбаатар: Баярлалаа. Уг нь би асуулт асууя гэж бодсон бас хоцорчихлоо. Хил, хэл, мал 3-тайгаа байхад хэн баян Монгол орон баян гээд Төрийн соёрхолт, Соёлын гавъяат зүтгэлтэн Зундуйн Дорж гуайн гоё алдартай 4 мөрт байгаа. Хил буюу улсаа хамгаалаад энэ уламжлалт МАА-гаа эрхлээд хөдөө амьдарч байгаа малчид байгаа. Тэгээд малаа маллахаа болиод бүгд Улаанбаатарт ороод ирэх аюул байгаа. Тэгээд тэр аюулаас нь улбаалсан эхний хэсгийг бид нар ишийдэх гээд 4 уулын дундах баахан асуудал яриад баахан хөтөлбөр яриад сууж байгаа юм. Тэгээд одоо бид нар хот улс болох гээд байгаа байхгүй юу. Эрсдэл нь. Тэгээд жишээлэхэд аялал жуулчлал гээд байгаа Мэлхий хад, Морьтой хөшөө, Улаанбаатарын түгжрэл, утаа үзээд л буцах гээд байна шүү дээ. Ирж байгаа жуулчид чинь бол энэ өргөн уудам нутаг онгон зэрлэг байгаль түүнд зохицож амьдраад байгаа энэ уламжлалт мал аж ахуй нүүдэлчин, зочломтгой малчин айл, энэ Төв Азийн соёлын голомтыг үзэж сонирхох бахархахаар ирж байгаа юм. Би тэгж бодож байгаа.

Батлут гишүүн бас сая хэллээ. Хөдөө аж ахуй сумын чиглэлд ярьсан. Тэгээд энэ манай дарга нар болохоор Батлут гишүүн яг үнэн яриад байна. Албан тасалгааны цонхоор амьдрал сайхан харагдана. Хөрсөн дээрээ очиж үзээгүй яам, Тамгын дарга нар яг үнэн хэлээд байна. Түвшин гишүүн бас хэллээ. Одоо энэ хариулт нь “Шинэ хоршоо”, “Цагаан алт” гээд байгаа юм. “Шинэ хоршоо” хөтөлбөр бодит байдал дээрээ зогсчихсон. Цагаан алт нь баахан лоозон байгаа. Яг бодитой түвшин гишүүний нэхээд байгаа тодорхой ажил байхгүй байгаа юм. Юу ч нөгөө бодлого тодорхой ажил байхгүй. Зүгээр л лоозон барьж бид нар яваад байна аа.

Тэгээд Байнгын хорооны дарга бас сая өөрөө хэллээ. Одоо энэ орлого олдог энэ солонгорсон хөдөө аж ахуйг явуулаач гээд. Үйлдвэр үйлдвэр бас дахин үйлдвэр.

Монгол бол ерөөсөө ийм л үгийг байнга хэлж явах ёстой юм шиг байгаа юм. Тэгээд миний яриад байгаа юмыг одоо энэ зах зухаасаа ч гэх юм уу энэ ойлгож эхлэх гээд байна. Ноосон бордооны үйлдвэр гэдэг чинь өөрөө малчны хотноос хуучин цагт монголчууд 2 удаа ноосоо хяргаад дотооддоо үйлдвэрлэл хийгээд нэмүү өртөг шингээдэг байсан бол одоо зүгээр 2 удаа хяргадгаараа хярга. Хяргаад тэгээд бид нар ноосон бордооны үйлдвэр хийгээд шууд экспортод гаргах боломжтой. Зүгээр жишээ хэлэхэд сая Киргизээс энэ зун бүр Ерөнхийлөгч нь Засгийн газрынхаа түвшинд ярьж байгаад 13 тонн түүхий ноостой орж ирээд 11 тонн бордоо болгоод гараад явчихсан байхгүй юу. Дэлхийд ганцхан байгаа үйлдвэр манай Монголд байгаа. Зөвхөн Монгол хонины ноосонд зориулчихсан үйлдвэр. Тэгээд энийг бид нар болохгүй бол бүр 21 аймагтаа барьчихад ноос өөрөө эдийн засгийн эргэлтэд орчихно. Одоо бол малаас бид нар бүгдийг иддэг учраас мах нь л үнэтэй байгаад байгаа. Бусад бүх түүхий эд хаягдаж байгаа. Яг үнэнийг нь хэлэхэд ноосыг ялангуяа талыг нь хаяад л талыг нь нэг авсан тал ноосныхоо талыг нь нэг угаасан болоод экспортод гаргаад л үлдсэнээр нь энэ нэг ширдэг хивсээ хийгээд л таарч байгаа юм. Ноосоор бол бид нар мөнгө олох боломж зах зээл нь гадаадад сая сая 100 сая тонноороо яригдаж байхад бид нар энд 2 мянгахан тоннын үйлдвэрийг 21 аймагтаа барьж чадахгүй 10-аас 15 тэрбум л болох байх. Үйлдвэр барьж чадахгүй ингээд худлаа цагаан алт, худлаа шинэ хоршоо яриад байгаа байхгүй юу. Яг бодитой ажлуудаа хийгээд өгөөч гэж хэлээд байхад ерөөсөө үг авахгүй байна аа. Сайд нь ч үг авахгүй байна. Яамныхан ч яадаг юм бүү мэд. Тэгээд одоо эндээс ингээд харахаар одоо энэ хөтөлбөр дээрээ байгаа. Бүсчилсэн бодлогын хүрээнд гээд хангайн бүсийг уламжлалт мал аж ахуй төрөлжсөн хот байгуулна дэд бүс болгоно. Энэ байхгүй шал худлаа. Хөдөө аж ахуй дээрээ бодлого нь бас байна. Өөрсдөө үнэнээ хэлээд биччихсэн байна. Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөрийн бүтээмж улсын

дунджаас 40 хувиар доогуур. Шинэ технологийн нэвтрэлт муу. Манай энэ үйлдвэрт цоо шинэ дэлхийн шинэ технологи байгаа. Энийг нэг анхаараад өгөөч. Тэгээд нөгөө малчид руугаа чиглэсэн хөдөө аж ахуй руугаа чиглэсэн бодлогын чинь үр дүн энд байна.

2023 оны байдлаар манай орны 264 гол мөрөн, 704 булаг шанд, 286 нуур тойром, 12 рашаан ширгэсэн.

Ц.Даваасүрэн: Үг хэлэх хугацаа дуусчихжээ. Зөв маш зөв юм ярьж байна шүү. Тэгэхдээ чамайг тэгээд хэлэхээр наадах чинь хувийн хэвилийн хийх ажил гээд л ингээд л хариулна. Одоо ингээд арван хэдэн жил би наадхыг чинь яриад ерөөсөө ганц хариулт дээр. Хувийн хэвилийн хийх ажил шүү дээ гээд л хаячихдаг. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг бид бүхэн хэлэлцээд дэмжээд явж байгаа. Зүгээр өнөөдрийн энэ хэлэлцүүлгийн явц дээрээс анхаармаар зүйлүүд бас байна. Юу гэмээр юм бэ дээ. Хамаагүй л яриад ч байгаа юм шиг зарим тохиолдолд. Дэмжих ёстой юмаа бид дэмжих ёстой. Энэ дэлхийн улс орнуудын хөгжлийн загвар тэндээс баримталж байгаа энэ төрийн бодлого дэмжлэгийнх нь асуудлуудыг бид авч л явах ёстой л доо. Одоо тэгээд татаасаасаа болоод, урамшууллаасаа болоод хөдөө аж ахуй маань бусдаас хоцроод байгаа тухай ярих гээд байгаа болохоор чинь хэцүү л болчхож байгаа байхгүй юу. Тэгээд тэгэмгүй байна гэж ний нуугүй хэлэхэд. Нэг хот хөдөөгийн тэнцвэрт байдлыг үнэхээрийн л хангая гээд байгаа бол хэдүүлээ энэ бүсчлэлийн бодлого дотроо дотоод бүсчлэлийнхээ зураглалыг их тодорхой болгомоор байна. Тэрэн дотроо тэргүүлэх үүрэгтэй гэдэг юм уу одоо эдийн засгийн таталцалтай сум суурин газруудаа тэргүүн ээлжид тэр хөгжлийг тэтгэсэн дэд бүтэцтэй нь болгож өгөх ёстой юм аа. Цахилгаан дулаан, шугам сүлжээ, зам харгуй бүх юмтай нь болгож

өгөх ёстой. Тэгж байж сая бид нар эдийн засгийг идэвхжүүлсэн дэд бүсүүд гэдэг юм уу, мужууд бий болох ёстой. Ингэж байж энэ өөрөө идэвхжилд орох ёстой юм. Тэрийгээ дагаж суурьшил нягтаршил нэмэгдэх ёстой. Ингэж байж л бид нарын олон олон юмны хариу гарах болов уу л гэж би ингэж нэг харах юм.

Хоёрдугаарт үйлдвэр ярьдаг юм. Тэгээд бүгдээрээ нэгэн ижил юм ярьцаагаад болж өгөхгүй байгаа юм. Тэр бүсийн түвшинд байх үйлдвэр технологийн паркуудтайгаа тэр аймгийн түвшинд гэдэг юм уу сумын түвшинд байгаа тэр ЖДҮ-үүд нь яаж холбогдох юм. Хаанаа ямар технологийн боловсруулалт хийж дараагийн шатдаа очиж уялдах юм. Ерөөсөө энэ үйлдвэр явахгүй байгаад байгаа юм чинь борлуулалт л байгаад байгаа шүү дээ. Тэгээд тэр борлуулалтаа үйлдвэр технологийн паркууд нь онцгойлон анхаардаг. Ер нь Монгол өөрийнхөө нэрээр гадагшаа гарч болох ямар бүтээгдэхүүнүүд байх юм гэдэг судалгаагаа хийгээд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийнхээ асуудлыг ахиутай хийж байж л сая энд жаал үйлдвэрлэлүүд амь орно. Тэрнээс үйлдвэр байгуулья гээд хэдэн төмөр угсраад ч нэг их учиргүй явчихдаггүй гэдгийг энэ олон жил харуулчхаж байгаа байхгүй юу.

Тийм учраас хамгийн ойрхон байгаад байгаа нь энэ ноос ноолуурын салбар тэргүүн ээлжид явчих бололцоо нь гарчхаад байгаа юм аа. Дамаан энэ ковид бидэнд олон муу зүйлийг авчирсан. Гэхдээ ноос ноолуур дээр бол нэлээн гайгүй жим зам мөрийг авчирч өгсөн. Тэгээд энийгээ цааш нь тэргүүлэх ээлжид аваад явчихмаар байна. Энэ мах махан бүтээгдэхүүний экспортын асуудал энэ тэр гээд уул нь ковидоос өмнө бид нэг хоёр, гуравхан орон руу гардаг байсан бол одоо энэнээс хойш бараг 9, 10 орон руу гардаг тийм жим мөр бий болгочоод байгаа. Энүүнийгээ ахиухан цааш нь хөгжүүлэлт хийх тухай асуудлууд л байгаад байгаа.

Тийм учраас энэ мэтчилнээр энэ нэг үйлдвэрүүдийг их бодитой харах, хоорондоо хорших, кластер хэлбэрээрээ явах тэгээд Монголын нэрээр гадагшаа гардаг тэр валют оруулж ирдэг бүтээгдэхүүнүүдээ тогтоож авч тэрийгээ нэлээн сайн хөгжүүлэлт хийж ажиллах тухай асуудал руугаа л энэ хөтөлбөр дотроо ахиухан хийж бодитой ормоор байгаа юм. Тэгэхгүй яриад яваад байхаар ерөөсөө юм урагшилж өгөхгүй байгаад байгаа. Тэгээд улсын төсвөөс үйлдвэр барьдаггүй юм тийм юм хийдэггүй юм л гээд ерөөсөө нэг ийм л юм л яриад л 10, 20 жил боллоо. Тэгээд тэрнийх нь гэм мөр юу байна вэ гэхээр зэрэг импортлогч, хэрэглэгч ийм л улс орон болж л хувираад л яваад байгаа. Гайгүй босож ирсэн хэдэн үйлдвэрээ дэндүү үнэтэй байна монопол байна гээд татан унагах бодлого авч хэрэгжүүлээд үймүүлээд.

Ц.Даваасүрэн: Тийм. Батжаргал гишүүн маш чухал юм хэллээ. Энэ чинь ноосоороо ноосон даавуу хийчхэж болно. Урагвай манайхаас бага хоньтой байхгүй юу. Тэгэхдээ ноосоороо 200 сая доллар олдог гээд л ингээд бодохоор манайд боломжууд зөндөө бий. Аубакир гишүүн үг хэлье.

Т.Аубакир: Баярлалаа. Ганц нэг санал хэлье. Микрофон сонсогдож байна уу? Хөдөө аж ахуйн яамныханд энэ эрдэм шинжилгээнийхээ хүрээлэнгүүдийг гол нь энэ харьяа харьяа яамдууд дээрээ авахгүй бол энэ сүүлийн үед Боловсролын яамны нэг мухарт байсан жишээлэх юм бол Хөдөө аж ахуйн яамны харьяа хөдөө аж ахуйн чиглэлийн эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд Хөдөө аж ахуйн яамнаасаа холдсоноосоо болоод үндсэндээ энэ ажлын уялдаа холбоо байхгүй болчихлоо л доо. Үүнтэй холбоотой гарч ирж байгаа маш олон сөрөг үр дагаврууд байна. Манай Монгол Улсын цаг агаар болон хөрсөнд тохирсон улаан буудай, үр үйлдвэрлэх шинжлэх ухааны үндэслэлтэй үр үйлдвэрлэх ажил үндсэндээ зогслоо.

Хамгийн сүүлд гарсан сорт бол Дархан 144. Зөвхөн үрийн будааны сортоор тогтохгүй энэ ургамлын ургамал хамгааллын хүрээлэнгүүдийн ажил алсарсантай холбоотой өнгөрсөн намрын, өнгөрсөн хаврыг хойш татсан импортын улаан буудайн дээр маш олон төрлийн Монгол Улсад байгаагүй хачиг хувалзууд орж ирсэн шүү дээ. Манай Хөдөө аж ахуйн яамныхан маш сайн мэдэж байгаа. Одоо тэрнээс хойш нэг өвөл өвөлжлөө. Одоо энэ нөгөө нэг импортоор орж ирсэн тэр хорхой шавжийн чинь устгалын ажил яг ямар түвшинд явж байгаа юм. Энийг бид нар чимээгүй өнгөрчихсөн юм. Бүүр Өмнөд Америкт байдаг хачиг хувалз хүртэл орж ирсэн байхгүй юу.

Гэтэл энэ иймэрхүү ажлууд дээр яг нухацтай эрдэм шинжилгээний түвшинд дүгнэлт гаргаж байх ёстой хүрээлэнгүүд маань Боловсролын яамны нэг мухарт байгаатай холбоотой. Ер нь ажил цалгардсан даа. Одоо энэ Хөдөө аж ахуйн яам гэдэг бол бэлэн боловсон хүчинтэй, материаллаг баазтай, туршилт хийх талбайгаар нь хангаад өгчих бололцоотой. Мөн хувийн хэвшилүүдтэй, үйлдвэрүүдтэй нь холбоод өгчих ийм коннекшнтэй ийм л яам байсан. Холдоод явчихсан байгаа. Өнгөрсөн парламентын үед бол хүрээлэнгүүдийг харьяа яамдууд руу нь өгье гээд дийлээгүй. Тийм учраас миний хувьд энэ Ж.Энхбаяр сайд маань энэ хүрээлэнгүүдээ өөрсдийнхөө харьяанд авъя гэж байгаа бодлогыг маш зөв гэж үзэж байгаа. Энэний чинь цаана энэ хүнс үйлдвэрлэж байгаа салбар маань өөрөө эрдэм шинжилгээний бодлогогүй болоод эхлэхээр зэрэг бид нар ард иргэддээ өгч байгаа хүнс үйлдвэрлэж байгаа салбар шүү дээ. Энэ маань ямар ч тийм эрдэм шинжилгээний юугүй гар хөлгүй болчихсон шүү, нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал дээр арьс шир, малын дайвар бүтээгдэхүүнүүдийг ярьж байна л даа. Яах вэ зүгээр 2022 оны 10 сарын 3-ны өдөр Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөс зөвлөмж хүргүүлсэн.

Энэний ачаар хонь, ямаа, үхрийн түүхий махыг ямар нэгэн квот хязгаарлалтгүйгээр гаргадаг болсон. Үүнтэй холбоотой яг махны экспортын зөвшөөрөл дээр байсан авлига л үндсэндээ алга болсон. Шууд ямар ч зөвшөөрөлгүй хонь, ямааны махыг гаргадаг болчихсон. Өмнө нь квот авна гээд л мөнгө төгрөг яригддаг байсан бол энэ асуудлыг шийдсэнтэй адилхан. Энэ арьс ширийг үнэхээр авъя гэж байгаа улс нь байвал түүхийгээр нь ч гэсэн гаргачхаж болдоггүй юм уу? Одоо энэ хөдөөгүүр та нар хар даа сүүлдээ нохой ч тоож идэхээ болилоо шүү дээ. Хонины арьсыг. Өөрсдөө үйлдвэрлэж чадахгүй. Баруун аймагт Ховд дээр яригдаж байсан үйлдвэр, Дархан дээр яригдаж байсан үйлдвэрүүд маань үндсэндээ улс төрөө дийлэхгүй ингээд зогсонги байдалтай болчихсон. Өөрсдөө үйлдвэрлэж чадахгүй, хүнд өгье өгч чадахгүй. Хөдөөгүүр нэг жалга гуу дагасан хонь, ямааны арьс хэвтэж байна. Ямааны арьс нэг 5, 10 мянган төгрөг болдог бололтой юм.

Тийм учраас энэ тэгээд яг адилхан авъя гэж байгаа улсууд нь байвал тэр арьс ширээ авдаг юм байгаа биз. Үгүй бол бодлогоор энэ 2 энэ төвийн бүсэд болон баруун аймагт байгаа энэ арьс ширний үйлдвэрийнхээ ажлыг жоохон эрчимжүүлмээр байна. Энэ дээр манай яамныхан гаргалгаа гаргах хэрэгтэй байна.

Гурав дахь асуудлууд маань энэ мал махны экспорттой холбоотой тусгай бүсүүдийг байгуулъя гэж байгаа нь энэ мах импортоор авдаг улсуудынхаа хил рүү ойрхон байхгүй бол бүтэхгүй ээ. Өчигдөр бас манай нэг гишүүн Булган аймагт гээд яриад байна лээ. Энэ өөрөө нөгөө тээвэрлэх журмаа зөрчиж эхэлдэг учраас Хятадын талаас нутгийн гүнээс авдаггүй байхгүй юу даа. Амьд малыг чинь. Тээвэрлэх явцад.

Ц.Даваасүрэн: Зөв зөв. Ер нь манайх 2 гол салбар нь хөдөө аж ахуй, уул уурхай учраас энэ 2 дээр хамгийн хүчтэй

эрдэм шинжилгээний хүрээлэн судалгааны төв байх ёстой юм шүү.

Дараагийн гишүүн Түвшин гишүүн уг хэлье.

Б.Түвшин: Хөдөө аж ахуйн чиглэлийн олон олон төслүүд, хөтөлбөрүүд явж ирдэг. Тэгээд яг үнэндээ ажилд ордоггүй ээ. Үндсэн гол шалтгаан нь бол энэ үндсэн тогтолцооныхоо шалтгааныг л олох хэрэгтэй байгаад байгаа юм. Хэчнээн арьс ширний үйлдвэр барилаа гээд тэгээд зөвхөн намартаа арьс ширээ цуглуулаад тэгээд эс үгүй бол тавхан арьс ширээ аваачаад өгдөг энэ тогтолцоо л байхгүй байгаад байгаа юм.

Тийм учраас үндэсний яалт ч үгүй хөдөө аж ахуй нүүдлийн мал аж ахуйг нүүдлийн чигээр нь эдийн засгийн эргэлтэд оруулах, махан дээрээ суурилсан Улаанбаатарын иргэд рүүгээ чиглэсэн махны чиглэлийн тогтолцоо хийж байж оруулж ирнэ. Гадаад дэлхийн улсуудад ч гэсэн тулгараад байгаа асуудал дандаа нөгөө пери буюу нөгөө түргэн мууддаг барааг намартаа жимсээ цуглуулчихаад яаж бүтэн жилийн турш шинэ байдлаар нь хадгалж хэрэглэх вэ гэдэг л толгойны өвчин. Манай мал аж ахуй бол энийг шийдэж болох асуудал. Худалдан авалтын тогтолцоо захиалга нь бэлэн байх юм бол 12 сарын турш малчдадаа захиалгыг нь өгөөд малаа яг сар сард нь нийлүүлэх хэрэгтэй. Энийгээ тогтолцоогоо үндэсний тогтолцоо болгоод хөгжүүлчих юм бол дагаад нөгөө арьс шир, ноос ноолуур, дагавар дайвар бүтээгдэхүүнүүд чинь өөрөө бэлтгэн нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоотой болчихно. Одоо экспорт дээр ч гэсэн тэр шүү дээ. Яг 3, 4, 5 дугаар сард ингээд орлого нь тодорхойгүй, худалдан авалт нь тодорхойгүй байж байгаа тохиолдолд нэг намартаа л бид нар зарна гэж ярьдаг. Тэгээд ганцхан удаагийн худалдан авалт хийгээд энийгээ экспорт гэж нэрлэх гээд байдаг биш яаж 12 сарын турш малыг амьдаар нь нийлүүлж хадгалах вэ гэдэг тэр пери

бүтээгдэхүүнийг судлаад яг энэ дээр нэг жоохон сэтгэл гаргаад үндэсний хэмжээний тогтолцоо явуулчих юм бол дагавар дайвар бүтээгдэхүүнүүд өөрөө бэлтгэн нийлүүлэлтийн тасралтгүй сувагтай болж байж үйлдвэр хөгжих үндэс суурь нь болно оо. Энийг бол судалгаа хийж байгаад тэгээд цааш нь ч гэсэн хамтраад ажиллаад явуулах ёстой. Түүнээс биш бид нар хаа хамаагүй нэг газар үйлдвэр барьчхаад нэг малчин 5 арьс бариад тийшээ явна гэж байхгүй. Энэний кластер гээд байгаа чинь ч гэсэн тэр шүү дээ. Малыг бид нар үндсэндээ мах чиглэлээр нь байнгын тасралтгүй авч байж дараа нь арьс шир, ноос ноолуур дагавар дайвар бүтээгдэхүүнүүд нь гарах юм байгаа юм шүү. Энэ тогтолцооны тухай бол та хэд бодоорой. Бас Ерөнхийлөгч дээр бол тэр үндэсний хүнсний аюулгүй байдал, дотоодын бэлтгэн нийлүүлэлтийн асуудал гэж яригдаж байна лээ. Энэ маш их зөв асуудал. Энэ дээр бол энэ тогтолцоон дээр очих юм бол малчид сар болгон орлоготой болчихно. Нөгөө талаасаа Улаанбаатарынх маань сар болгон шинэ мах идэх боломжтой болчихно. Бид нар үндэсний хүнсний тогтолцоотой болчихно. Энийг дагаад томоохон бэлтгэн нийлүүлэлтийн сувгууд гарч ирж байж үйлдвэрүүд хөгжих юм байгаа юм.

Хоёрдугаарт нийгмийн даатгал дээр нийгмийн даатгал гэдэг бол өөрөө яг ажил олгогч өнөөдөр бол нийгмийн тодорхой асуудлыг шийдэж байгаа боловч ажил олгогчдын хувьд бол толгойны өвчин болчихсон. Бид нар төсвийнхөө зардлаа ч өсгөө, төсвөө ч нэмэгдүүлье гээд байгаа нь бол хувийн бизнесүүдийг нэмэгдүүлж ДНБ өснө. Гэтэл тэр хүмүүсийн орлогоос хүн амын орлогын албан татвар авахаас гадна нийгмийн даатгалын.

Ц.Даваасүрэн: Байхгүй. Энэ дээр минут байдаггүй юм. Мөнхсоёл гишүүн үг хэлье.

Б.Мөнхсоёл: Баярлалаа. Нэлээн удаан бас хуралдлаа. Тэгээд маш товчхон хурдан саналаа хэлчихье гэж бодож байна. Олон санал байгаа боловч 2 гол энд түрүүний 2 цагт дурдагдаагүй асуудал дээр ялангуяа саналаа хэлчихье ээ. Энэ хэвлэлийн эрх чөлөөний асуудал байгаа. 4.1.2. Тэрэн дээр бас ийм гол санааг оруулмаар байгаа саналыг. Олон нийтийн радио телевизийн бие даасан байдлыг хангахтай холбоотой. Тэгээд хариуцлагатай, хараат бус иргэдийг соён гэгээрүүлэх хөгжүүлэхэд чиглэсэн нийтлэлийн бодлогыг дэмжих зорилгоор эрх зүйн орчныг шинэтгэх энэ чиглэлийн энэ заалтыг оруулмаар байна аа. Үйл ажиллагааны хөтөлбөр дээр.

Дараагийн нэг гол санал бол 4.1.4-тэй холбоотой. Энэ заалт дээр ил тод байдал хяналтыг агуулсан байгаа. Тэгээд тэрэн дээр болохоор төрийн үйл ажиллагааны ил тод байдлын зарчмыг бодитой хэрэгжүүлж, төрийн болон байгууллагын нууцын хуульд өөрчлөлт оруулж, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангамаар байна гээд. Бид нар түрүүний 2, 3 жилүүдэд яригдсан нэг гол асуудал *no dable standart* гээд байгаа шүү дээ. Аливаа зүйлд хэн, хаана, ямар асуудалд орсон нь хэнтэй ямар эрх мэдэлтэй хүн ямар өндөр албан тушаалтантай ойрхноосоо хамаарч асуудал яг ийм хүнийг ялгаварлалгүйгээр шийдэгдэхгүй байгаа маш олон ийм нийгмийг доргиосон ийм асуудлууд үүсдэг. Тэгээд шүүх засаглалд бас зарим иргэд маань хангалттай итгэлцэл үзүүлдэггүйгээс байхгүйгээс болоод бид нар шийдэл, аливаа шийдэлд сэтгэл хангалуун бус байдал үүсдэг. Тийм болохоор энэ нийтдээ ил тод байдал хяналт бол маш чухал. Энэ дээр ийм саналыг нэмж оруулмаар байгаа юм ингээд товчхон дуусгая. Боломж олгосонд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Гишүүд маань чухал үг хэллээ. Бас энэ санаануудыг манай энэ мөрийн хөтөлбөрийн ажлын хэсэгт орж ирсэн холбогдох яамдынхан

бас анхаараарай. Өнөөдөр бид нар нэлээн том тэлсэн төсөвтэй явж эхэллээ.

2023 онд 12 их наяд байсан төсөв 2024 онд 24 их наяд болж 2 дахин өссөн. Төсөв тэлсэн. Төсөв тэлнэ гэдэг чинь одоо зарлага нэмэгдэж байгаа гэсэн үг. 30 их наядын зарлагатай болж байна гэдэг чинь маш том эрсдэл дагуулж байгаа. Бид нар 3 их наядын зарлагыг санхүүжүүлэгддэг байсан бол 10 жилийн дараа 30 их наядын зарлагыг санхүүжүүлдэг болж ирж байна шүү дээ. Гэтэл энэ хугацаанд экспортын орлого нэмэгдэх үйлдвэрлэл Монголд бий болсон уу нэг ч бий болоогүй. Юугаар санхүүжүүлж байгаа юм нүүрсээр. Ганцхан нүүрсээр. Дээр нь яах вэ нэг алт, зэсний жсоохон мөнгө.

Тэгэхээр энэ байдал маш том эрсдэлийг Монголын эдийн засагт бий болгож байгаа. Нүүрсний үнэ унах юм бол нүүрсний нийлүүлэлт багасах юм бол бид эдийн засгийн хувьд маш хүнд байдалд орохоор ийм эдийн засгийн бүтэц рүү явж байна шүү дээ. Ганцхан орлогоос хамаардаг. Тэгэхээр гишүүдийн хэлээд байгаа энэ бол зөв. Бид нар ирэх 4 жилийн мөрийн хөтөлбөр дээр ч гэлээ гэсэн ийм юмнуудыг анхаарах ёстой. Эдийн засаг яаж солонгоруулах юм. Бидний чадаж байгаа юм бол хөдөө аж ахуй. Хөдөө аж ахуй дээр асар их боломжууд байна уу. Байна. Тэгэхдээ яриад л байна хийж чадахгүй байна. Нөгөөдөх нь аялал жуулчлал. Бидний чадах ёстой энэ 3 салбар дээр бол бид нар маш том ач холбогдол өгөх, дээр нь уур уурхайн бүтээгдэхүүнээ түүхийгээр нь гаргадаг байж болохгүй ээ. Боловсруулалт хийх юм бол нэмүү өртөг 2 дахин өснө. Адаглаад үйлдвэрлэл бий болгоё гэж байгаа бол энэ хөдөө аж ахуй, уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ боловсруулах үйлдвэр гэсэн энэ чиглэлүүдийг бид нар хөгжүүлээд явчих юм бол харин бидний орлого олох боломж бол байгаа харагдаад байгаа юм. Гэтэл өнгөрсөн хугацаанд юу ярьсан. Энэ болохгүй байгаа юмыг ерөөсөө бүтэц рүү ярьж байгаа. Үндсэн хууль өөрчлөхгүй бол

болохгүй байна гээд л. Үгүй энэ сайд нарыг огцуруулаад байгаа ерөөсөө болохгүй байна гээд л ингээд л. Давхар дээлтэй байхгүй бол ерөөсөө явахгүй юм байна гээд л ингээд. Тэгэхдээ энэ бүх өөрчлөлтүүдийг хийгээд Их Хурлыг маш чадамжгүй болгосон байхгүй юу. Үгүй тэгээд амьдрал сайжирсан уу, улс хөгжсөн үү? Ядуурал буурсан уу? Үгүй. Бүх өөрчлөлтүүдээ хийсэн. Үндсэн хуулиа өөрчилсөн, сайд нараа огцуруулахаа больсон. Хариуцлага ярихаа больсон. Засгийн газар нь эрх мэдэлтэй болсон. Гэхдээ Монгол хөгжихгүй хэвээрээ л байгаад байгаа. Яагаад хөгжихгүй байгаа гэж. Хүний хөгжлийн асуудлыг ур чадвартай хүнийг, мэдлэгтэй хүнийг дээдэлдэг болж байж тэгээд шинжлэх ухаанч хандлагыг бий болгож байж хөгжинө. Өнөөдрийн байгаагаараа бол ямар ч Үндсэн хуулийг 10 өөрчлөөд, мянга өөрчлөөд, 100 өөрчлөөд өөрчлөгдөхгүй. Тийм учраас энэ гишүүдийн хэлээд байгаа дээр бол анхаараарай. Тэгээд харин бас яах вэ одоо энэ сүүлийн үед орж ирсэн энэ манай шинэ гишүүд бас энэ чиглэлийн юман дээр бас нэлээн ач холбогдол өгөөд байгааг би бас талархалтай хүлээж авч байгаа юм.

Тэгэхдээ та нар ингээд 1 2 жил болоод ахиад дуусаад алга болчхов. Ер нь хамгийн гол юм хүн шүү дээ. Хүн л бүгдийг хийж байгаа. Тийм учраас тэр хүний хөгжлийн асуудал дээр, хүнээ дээдлэх юман дээр бид нар цаашидаа энэ мөрийн хөтөлбөрүүд дээрээ анхаараад ингээд явах ёстой. Ингээд мөрийн хөтөлбөртэй холбогдуулж асуулт асууж, үг хэлж дууслаа.

Мөрийн хөтөлбөрийг дагаж орж ирсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух хүн байна уу?

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад тогтоол орж ирсэн байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух хүн байна уу?

Асуух хүн алга байна аа. Харин нэг санал ирсэн байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулаад зарчмын зөрөөтэй нэг санал гаргасан байна. Батлут гишүүн.

Ирцээ бүрдүүлэхгүй бол энэ уначихаар байна. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулаад гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд ирцээ бүрдүүлье. Батлут гишүүний гаргасан санал байна. Уначих гээд байна шүү айн.

Уг нь намайг ярьсны дараа л ярих ёстой л доо. Хэрвээ асуувал тайлбарлах ёстой л доо.

Би ингээ Батлут гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүгдэд танилцуулчихъя. Тэгээд гишүүн тайлбарлах. Тэгээд тэрний дараа санал хураалт явуулъя.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж байна.

1.3.3-д Улаанбаатар-Шар Хөтөл-Эрдэнэт авто зам гэж нэмэх саналыг оруулж байгаа юм байна. Энэ саналтайгаа холбогдуулаад Батлут гишүүн тайлбар өгье.

Батлут гишүүний микрофоныг өгье.

Д.Батлут: Энэ зам бол Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хавсралтын 2.4.75 дугаарт Улаанбаатар-Шар Хөтөл-Эрдэнэт 100 км хатуу хучилттай авто зам төсөл, Орхоны гүүр, Төв аймгийн Жаргалант гэж мөн үндсэн чиглэлтэй нийцүүлэн баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны Хөгжлийн төлөвлөгөөний 4.3.1.24-д Улаанбаатар-

Шар Хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын авто замын Орхон сумын уулзвар төгс хатуу хучилттай 100 км авто зам барих гэж батлагдсан.

Тийм учраас энийг 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нэгийн 1.3.3-ын хойд бүс, байгаль, аялал жуулчлалын төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс хэсэгт Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн 100 км авто замыг барина гэж нэмж оруулах саналтай байна. Үндсэндээ энэ төслийн хөрөнгө оруулалтын эхний ажил нь хийгдэхээр Монгол Улсын төсөвт суучихсан. Үлдсэн санхүүжилтийг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр Европын сэргээн босголтын банкттай бас хэлэлцэж Засгийн газрын түвшинд дэмжчихсэн явж байгаа юм аа.

Тийм учраас энэ 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт оруулж өгөх нь зүйтэй гэж үзэж зарчмын зөрүүтэй санал гаргасан болно. Дэмжиж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн, Батболд гишүүн, Батбаяр гишүүн нар ороод ирвэл ирц бүрдэх гээд байна. Санал хураалт явуулах боломжтой болох гээд байна. Батжаргал гишүүнийх явдалтай шүү. Ороод ирлээ, ороод ирлээ. 2 гишүүн ороод ирлээ. Ингээд санал хураалт явуулъя. Би та бүхэнд Батлут гишүүний гаргасан Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт авто замын энэ хөрөнгө оруулалтын асуудлыг үйл ажиллагааны хөтөлбөрт нэмж оруулъя гэсэн энэ заалтыг танилцуулчихсан байгаа.

Энэ Батлут гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Саналыг 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж 64.7 хувиар дэмжигдсэн байна.

Санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр мөн хөтөлбөрийг дагаж батлах тухай Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын миний бие ТББХ-ны хуралдаанд танилцуулъя.

Та 2 ТББХ-нд байгаа юу? Байхгүй юу. Би өөрөө танилцуулчихъя.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Байнгын хорооны хуралдаан дууссаныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

15.18 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*